



Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг 4-р хороо,
Самбуугийн гудамж 13/02,
Глобал бизнес центр, 503 тоот

Ажлын утас: +976-70129665
Гар утас: +976-99069665
Э-мэйл: info@mjlattorneys.mn
Вэб: www.mjlattorneys.mn

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2023 ОН**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:	2
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	3
1.1. Үнэлгээ хийх үндэслэл	3
1.2. Үнэлгээ хийх хүрээ	3
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр.....	5
1.5. Шалгуур үзүүлэлтийн томъёолол	5
1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар	13
ХОЁР. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	14
2.1. Салбарын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх	14
2.2. Салбар хоорондын зохицуулалт	30
2.3. Хамгаалалтын зурвас газрын хэмжээ, инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас газрын давхардал	33
2.4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит	36
2.5. Салбарын улсын байцаагчийн асуудал, маргаан шийдвэрлэх зохицуулалтын асуудал	40
2.6. Дугаартайгаа шилжих үйлчилгээний хэрэгжилт	44
2.7. Үндсэн сүлжээтэй холбоотой заалтуудын хэрэгжилт	50
2.8. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан.....	52
2.9. Интернэтийн дундын холболтын журам.....	56
2.10. Судалгаа, шинжилгээний байгууллага	59
2.11. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт.....	61
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	63

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГ:

Судалгааны багийн ахлагч: Г.Пүрэвдорж (LL.M)

Судалгааны багийн гишүүд: М.Мөнхжаргал

О.Мөнхболд

Б.Эрдэнэменх

Э.Золзаяа (MPA)

Х.Билгүүн (LL.M)

Э.Дөлгөөн

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ЦХХХЯ – Цахим хөгжил, харилцаа холбооны яам

ХХЗХ – Харилцаа холбооны зохицуулах хороо

ХХтХ – Харилцаа холбооны тухай хууль

ЗГ – Засгийн газар

ШӨХТГ – Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

БНҮҮС– Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

ДШҮТ - Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээний төв

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий “Харилцаа холбооны тухай хууль”-ийг Монгол Улсын Их Хурлаас 2001 оны 10-р сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд тус хууль өдгөө 22 дахь жилдээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд нийт 20 удаагийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Засгийн газраас харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр зарлаж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх зорилго бүхий "Цахим Үндэстэн" дунд хугацааны зорилтот хөтөлбөр /2022-2027/-ийг баталсан. Дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй энэ үед Монгол улсын цахим хөгжил, харилцаа холбооны салбарын гол хууль болох Харилцаа холбооны тухай хууль нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэх, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд гарч буй хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, хууль анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч байгаа эсэхийг судалж, дүн шинжилгээ хийхэд Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зорилго оршино.

Монгол улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасныг үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН нарын хооронд байгуулагдсан Г/28 дугаар “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний дагуу Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН нь 2023 оны 05-р сарын 24-ний өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

1.2. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭ

Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхдээ агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц *Харилцаа холбооны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, харилцаа холбооны сүлжээ, харилцаа холбооны сүлжээг хамгаалах, хяналт хариуцлага* гэсэн 5 бүлгээс салбарын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч

байгууллагуудын бүрэн эрх, салбар хоорондын зохицуулалт, хамгаалалтын зурвас газартай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, салбарын улсын байцаагчийн асуудал, дугаартайгаа шилжих үйлчилгээний хэрэгжилт, үндсэн сүлжээтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилт, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалт, интернэтийн дундын холболтын асуудал, судалгаа, шинжилгээний байгууллага, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт гэсэн 11 асуудлаар үнэлгээний хүрээг тогтоож, тус бүрд тохирох шалгуур үзүүлэлтүүдийг томъёолсон.

Харилцаа холбооны хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох, уг хуулийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрсэн байдлыг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээ хийж, тохирох хэмжүүрийг сонгон, холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийсэн бөгөөд үнэлгээг дараах алхмуудын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож томъёолох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Богино хугацаанд төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах аргыг сонгож цуглуулсан.

Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ тус хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, төлөвлөгөө, хувь хэмжээ тогтоосон акт, аргачлал, нөхцөл, шаардлагыг үнэлээгүй бөгөөд эдгээр ажил нь захиалагчтай байгуулсан гэрээнд тусгагдаагүй болно.

1.3. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

Үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгож авсан болно. Үүнд:

- а) “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
- б) “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт нь хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
- в) “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлт нь хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр

дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж үнэлэхэд тохиромжтой юм.

Шалгуур үзүүлэлт (Хүснэгт №1)-ийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1.4. ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭР

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Харилцаа холбооны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо нь хуулийг хэрэгжүүлэгч чиг үүрэг бүхий байгууллагын тайлан, статистик, судалгааны бүтээл зэрэг болно. Түүнчлэн тус хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтоох бол хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Дээрх харьцуулалтын хэлбэр (Хүснэгт №1)-ийн хүрээнд Харилцаа холбооны тухай хуулиар тогтоосон хамгаалалтын зурвас газрын хэмжээ, инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас газрын зохицуулалт, дугаартайгаа шилжих үйлчилгээний зохицуулалт, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зорилго зэрэг нь өнөөгийн өөрчлөгдөн буй цахим хөгжил, харилцаа холбооны салбарын хөгжлийн чиг хандлагад нийцэж байгаа эсэх, салбарын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх, салбар хоорондын харилцааг хуульчилсан байдал, тэдгээрээс үүдэн Харилцаа холбооны тухай хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

1.5. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томьёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлан ажиллалаа.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийн томъёолол

№	Судлах асуудал	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Мэдээлэл цуглуулах арга
1	Салбарын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх	5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа эсэх • Хүлээн зөвшөөрөгдсөн байдал 	<ul style="list-style-type: none"> • Байх ёстой, болон одоо байгааг 	<ul style="list-style-type: none"> • ЗГ-т хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах
		6 дугаар зүйл. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх			<ul style="list-style-type: none"> • ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь харилцаа холбооны салбарын харилцаануудыг бүрэн хамарч чадаж байгаа эсэх? • ЦХХХЯ-ны хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал? • Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.2-т “харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах” гэж заасан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах процесстой нийцэх эсэх, нэршлийг өөрчлөх шаардлагатай эсэх? • ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь бусад субъектуудын хуулиар олгогдсон бүрэн эрхүүдтэй давхардаж байгаа эсэх? • Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.в дэх заалт нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах

					<ul style="list-style-type: none"> • Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “баримтлах чиглэл” батлах эрхтэй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай зөрчилдөх эсэх? 	
		8 дугаар зүйл. Харилцаа холбооны зохицуулах хороо. 9 дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх			<ul style="list-style-type: none"> • ХХЗХ-ны эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлсон байдал? • ХХТХ-ийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилохоор заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эсэх? • ХХЗХ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах
2	Салбар хоорондын зохицуулалт	6 ¹ дүгээр зүйл. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх салбар хоорондын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа эсэх • Хүлээн зөвшөөрөгдсөн байдал 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа хууль батлагдсана ас хойш 	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчим хэрхэн хангагдаж байна вэ? • Салбар хоорондын харилцаанд нэмж тусгах шаардлагатай субъект байгаа эсэх? • Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөл? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах

3	Хамгаалалтын зурвас газрын хэмжээ, инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас газрын давхардал	28 дугаар зүйл. Зурвас газар 29 дүгээр зүйл. Зурвас газарт тавих хяналт	<ul style="list-style-type: none"> • Хүлээн зөвшөөрөгдсөн байдал • Практикт нийцэж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> • Байх ёстой, болон одоо байгааг 	<ul style="list-style-type: none"> • Үйлчлэгчид хамгаалалтын зурвас газрыг газрын дуудлага худалдаагаар олгож буй нь сөрөг үр дагавартай байгаа эсэх? • Газрын дуудлага худалдааны анхны үнэ тогтоох эрх зүйн зохицуулалт нь тодорхой байгаа эсэх? • Үйлчлэгч хамгаалалтын зурвас газарт хяналтаа хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байгаа эсэх? • Хамгаалалтын зурвас газрын хэмжээ үйлчлэгч нарт хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах
4	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит	30 ¹ дүгээр зүйл. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа эсэх • Хүлээн зөвшөөрөгдсөн байдал 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа хууль батлагдсана ас хойш 	<ul style="list-style-type: none"> • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит байх шаардлагатай эсэх? • Мэдээллийн аюулгүй байдлын аудит, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит 2 нь давхардсан аудит эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх авсан хуулийн этгээд байгаа эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох нь Зөвшөөрлийн тухай хуульд нийцэж байгаа эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал батлагдсан эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах

					<ul style="list-style-type: none"> • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалт ЗГ-аас баталсан эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан захиргааны байгууллага байгаа эсэх? 	
5	Салбарын Улсын байцаагчийн асуудал, маргаан шийдвэрлэх зохицуулалтын асуудал	<p>8 дугаар зүйлийн 8.7 дахь заалт</p> <p>30 дугаар зүйл. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлчилгээнд тавих хяналт</p> <p>31 дүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практикт нийцэж 	<ul style="list-style-type: none"> • Байх ёстой болон одоо байгааг 	<ul style="list-style-type: none"> • Төрийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн эрх үүрэг хэрэгжиж байгаа байдал? • Салбарын улсын байцаагчийн үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой эсэх? • ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг болон түүний улсын байцаагчийн өргөдөл, гомдол, мэдээллээр хяналт шалгалт явуулах чиг үүргээс зааглагдсан эсэх? • Улсын байцаагчийн тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь ХХЗХ-ны энэ талаарх бүрэн эрхээс ялгагдаж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах
6	Дугаартайгаа шилжих үйлчилгээний хэрэгжилт	<p>9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх.</p> <p>9.1.13 дахь заалт</p>	<p>Зорилгод хүрсэн түвшин</p> <p>Хүлээн зөвшөөрөгдсөн байдал</p> <p>Практикт нийцэж байгаа эсэх</p>	<p>Одоо байгаа хууль батлагдсанаас хойш</p>	<ul style="list-style-type: none"> • ХХЗХ дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, зохицуулалтын журам батлах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх. • Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлж чадсан эсэх, чадаагүй бол үүний шалтгаан нөхцөл юу байв? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Баримт бичиг шинжлэн

		25 дугаар зүйл: Үйлчлэгчийн эрх, үүрэг. 25.2.9 дэх заалт			<ul style="list-style-type: none"> Оператор компаниуд хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх үүргээ сайн дураар биелүүлж байгаа эсэх. Дугаартайгаа шилжих үйлчилгээ нэвтрээгүйгээс шалтгаалж хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэх. 	судлах
7	Үндсэн сүлжээтэй холбоотой заалтуудын хэрэгжилт	6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт 17 дугаар зүйлийн 17.4 дахь заалт	<ul style="list-style-type: none"> Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> Байх ёстой болон одоо байгаа 	<ul style="list-style-type: none"> Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг баталсан эсэх? Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл байгаа эсэх? Үндсэн сүлжээг төр болон өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж байгуулж өмчлөхөд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх, өмчлөхтэй холбоотой асуудлаар маргаан дагуулж байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах Тоо баримт шинжлэн судлах
8	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалт	11 дүгээр зүйл. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	<ul style="list-style-type: none"> Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа эсэх Хүлээн зөвшөөрөгдсөн байдал 	<ul style="list-style-type: none"> Одоо байгаа хууль батлагдсана ас хойш 	<ul style="list-style-type: none"> Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн дүн болон хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн тоо, төсөвт өртөг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалтын талаар үйлчилгээ эрхлэгчид болон төрийн болон зохицуулалтын байгууллагын албан хаагчид нэгдсэн ойлголттой байгаа эсэх? Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалт хоорондоо зөрчилдөж байгаа эсэх? Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгийг бүрдүүлэхэд үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах Тоо баримт шинжлэн судлах

					эрхлэгч нарт тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл? • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан зорилгодоо хүрсэн эсэх?	
9	Интернэтийн дундын холболтын асуудал	6 дугаар зүйлийг 6.1.14.г дэх заалт	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практик хэрэгжих байдал 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа хууль батлагдсана ас хойш • Байх ёстой болон одоо байгааг 	<ul style="list-style-type: none"> • Яам бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх? • Журмын төсөл өнөөдрийг хүртэл батлагдаагүй шалтгаан нөхцөлийн талаар? • Журмын хэрэгцээ шаардлага? • Журам батлагдаагүйгээс интернэт үйлчилгээ эрхлэгчдийн дунд дундын холболттой холбоотой хүндрэл, бэрхшээл гарч буй эсэх? • Уг хүндрэл бэрхшээлийг зохицуулж чадсан эсэх? Зорилгод хүрсэн байдал? • Яаманд журам батлах бүрэн эрх олгосон нь практикт нийцэж байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах
10	Судалгаа, шинжилгээний байгууллага	5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа хууль батлагдсана ас хойш 	<ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам батлагдсан эсэх, батлагдаагүй бол түүний шалтгаан? • Судалгаа, шинжилгээний байгууллагын хэрэгцээ шаардлага байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах
11	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт	32 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 33 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Зорилгод хүрсэн түвшин • Практик нийцэж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> • Одоо байгаа хууль батлагдсана ас хойш • Тохиолдол судлах 	<ul style="list-style-type: none"> • ХХТХ-ийг зөрчсөн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд бүрэн тусгасан эсэх • Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага нь үр нөлөөтэй байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах • Тоо баримт шинжлэн судлах

1.6. ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН ТАЛААР

Үр дагаврын үнэлгээний мэдээллийг Харилцаа холбооны тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгааны тайлан, ЦХХХЯ болон ХХЗХ-оос гүйцэтгэгчид ирүүлсэн тайлан, тоон мэдээ, ХХЗХ-ны 2013 оны 10-р сарын 04-ний өдрийн 57 дугаар “Зохицуулалт шинэчлэн батлах тухай” тогтоол, 2015.06.12-ны өдрийн 26, 2015.09.30-ны өдрийн 49, 2016.02.05-ны өдрийн 05, 2016.05.25-ны өдрийн 28, 2020.04.29-ний өдрийн 23 дугаар тогтоол, ХХЗХ-ны даргын 2014 оны 09 сарын 29-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/176 дугаар тушаал, Үндэсний дата төв УТҮГ-аас 2023 оны 01-р сарын 11-ний өдөр “Ай Эн Мобайл Нэтворк” ХХК-д хүргүүлсэн 01/09 тоот “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичиг, Интернэтийн үйлчилгээ эрхлэгч “Ондо” ХХК-аас ХХЗХ-д хүргүүлсэн 2022.08.03-ны 22/588 тоот, “Үндэсний дата төв” УТҮГ-д хүргүүлсэн 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн 23/83 тоот албан бичиг, “Ондо” ХХК-аас Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд хүргүүлсэн 2023 оны 02-р сарын 28-ны өдрийн 22/118 тоот албан хүсэлт зэрэг албан эх сурвалж болон статистик тоо баримт зэрэг холбогдох судалгаа, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ.

- а) **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны тайлан, статистик тоо баримт, хуулийн үзэл баримтлал зэрэг эх сурвалжийг ашигласан.
- б) **Холбогдох субъектүүдтэй уулзаж, ярилцлагын аргаар мэдээлэл авах:** Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг үнэн зөв, бодитой гүйцэтгэх, харилцаа, холбооны салбарын харилцаанд оролцогч субъектүүдээс эрх тэгш мэдээлэл авах, тэдгээрийн байр суурь, хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулах зорилгоор нийт 26 ажилтан, албан хаагчидтай уулзсан. Үүнд:

ЦХХХЯ (8),

ХХЗХ (5),

Газар зохион байгуулалт, геодези

зураг зүйн газар (2),

Мэдээлэл харилцаа холбооны

үндэсний ассоциаци ТББ (1),

Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК (1),

Мэдээлэл технологийн үндэсний парк (2)

харилцаа холбооны үйлчилгээ

үзүүлэгч хувийн хэвшлийн

байгууллагууд (7)

ХОЁР. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

2.1. САЛБАРЫН ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮРЭН ЭРХ

Үнэлэх хэсэг	<p>5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх</p> <p>5.1. Засгийн газар харилцаа холбооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1. харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;</p> <p>5.1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо байгуулах, түүний дүрмийг батлах;</p> <p>5.1.3. бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам батлах.</p> <p>5.1.4. харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;</p> <p>5.1.5. харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журмыг батлах.</p> <p>6 дугаар зүйл. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>6.1. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.1. харилцаа холбооны тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>6.1.2. харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, биелэлтийг зохион байгуулах;</p> <p>6.1.3. харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сөргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>6.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах;</p> <p>6.1.5. сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө батлах;</p> <p>6.1.6. бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>6.1.7. харилцаа холбооны үйлчилгээг найдвартай, шуурхай, чанартай байлгах, захидал харилцааны нууцын хамгаалалтад хяналт тавих;</p> <p>6.1.8. харилцаа холбооны мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах;</p> <p>6.1.10. үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>6.1.12. бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэн зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг Ерөнхий сайдад тайлагнах;</p> <p>6.1.13. харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогыг</p>
---------------------	---

	<p>хэрэгжүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;</p> <p>6.1.14.харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон дараах журмыг батлах:</p> <p>6.1.14.а.төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам;</p> <p>6.1.14.в.төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам;</p> <p>6.1.14.г.интернэтийн дундын холболтын журам.</p> <p>6.1.15.Энэ хуулийн 5.1.4-т заасан баримт бичигт дараах бодлогын асуудлыг тусгана:</p> <p>6.1.15.а.харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх талаарх мэдлэг, боловсролыг бүх нийтэд эзэмшүүлэх;</p> <p>6.1.15.б.бусад салбарын болон салбар хоорондын харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах;</p> <p>6.1.15.в.харилцаа холбоо, мэдээллийн технологийн инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэх;</p> <p>6.1.15.г.харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах;</p> <p>6.1.15.д.төрийн байгууллагын үйл ажиллагаа болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажлын харилцан уялдааг хангах;</p> <p>6.1.15.е.үндсэн сүлжээний оновчтой бүтцийг бий болгох, техник, технологи нэвтрүүлэх;</p> <p>6.1.15.ж.бусад.</p> <p>6.1.16.харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;</p> <p>6.1.17.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.</p> <p>6.1.18.зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн Зохицуулах хорооны саналыг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох;</p> <p>6.1.19.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>6.2.Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөхдөө эрх бүхий байгууллага нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө.</p>
--	---

8 дугаар зүйл. Харилцаа холбооны зохицуулах хороо

8.1. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ ажиллана.

8.2. Зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэнэ.

8.3. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.

8.4. Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно.

8.5. Зохицуулах хорооны даргыг нэг удаа улируулан томилж болно.

8.6. Харилцаа холбооны салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил, түүнээс 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны даргаар, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны гишүүнээр томилно:

8.6.1. эдийн засаг, мэдээлэл холбоо, техник, хууль зүй, удирдлагын дээд боловсролтой, өндөр мэргэжил, ажлын туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай;

8.6.2. Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.

8.7. Зохицуулах хороонд харилцаа холбооны улсын байцаагч ажиллана.

8.8. Зохицуулах хороо нь ажлын албатай байна.

8.9. Зохицуулах хороо нь орон нутагт орон тооны бус гишүүдээс бүрдэх салбар зөвлөлтэй байж болно.

8.10. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөс санхүүжинэ.

8.11. Зохицуулах хороо нь ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Засгийн газарт тайлагнана.

8.12. Зохицуулах хороо нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэлнэ.

8.13. Зохицуулах хороо нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж болно.

9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

9.1. Зохицуулах хороо харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

9.1.2. хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл,

	<p>шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;</p> <p>9.1.3.харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.4.сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.5.харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд зүй ёсны монополь болон давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах, батлах;</p> <p>9.1.6.харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.7.бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах;</p> <p>9.1.8.харилцаа холбооны стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>9.1.9.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;</p> <p>9.1.10.радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.11.энэ хуулийн 6.1.4-д заасан журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтоох;</p> <p>9.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;</p> <p>9.1.13.дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, уг үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын журам батлах;</p> <p>9.1.14.домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.15.тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;</p> <p>9.1.16.Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах.</p> <p>9.1.17. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • ЗГ-т хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал? • ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь харилцаа холбооны салбарын харилцаануудыг бүрэн хамарч чадаж байгаа эсэх? • ЦХХХЯ-ны хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал? • Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.2-т “харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах” гэж заасан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах процесстэй

	<p>нийцэх эсэх, нэршлийг өөрчлөх шаардлагатай эсэх?</p> <ul style="list-style-type: none"> • ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь бусад субъектуудын хуулиар олгогдсон бүрэн эрхүүдтэй давхардаж байгаа эсэх? • Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.в дэх заалт нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа эсэх? • Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “баримтлах чиглэл” батлах эрхтэй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай зөрчилдөх эсэх? • ХХЗХ-ны эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлсон байдал? • ХХтХ-ийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилохоор заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эсэх? • ХХЗХ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал?
--	--

2.1.1. ХХтХ-ийн 5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх.

а) ЗГ-т хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал?

ХХтХ-ийн 5 дугаар зүйлд зааснаар ЗГ-т 5 төрлийн бүрэн эрхийг олгожээ. Эдгээр бүрэн эрхүүдээс хуулийн 5.1.2-т заасан “Харилцаа холбооны зохицуулах хороо байгуулах, түүний дүрмийг батлах;” бүрэн эрх хэрэгжиж ЗГ-ын 2002 оны 01 сарын 25-ны “Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулах, дүрэм батлах тухай” 15 дугаар тогтоолоор анх ХХЗХ-г байгуулж, дүрмийг баталж, улмаар 2016 оны 05 сарын 23-ны өдрийн “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм шинэчлэн батлах тухай” 268 дугаар тогтоолоор дүрмийг шинэчлэн баталж, дээрх тогтоолууд хэрэгжиж мөрдөгдөж байна.

ХХтХ-ийн 5.1.3-т заасан “бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам батлах” бүрэн эрх хэрэгжиж ЗГ-ын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 205 дугаар тогтоолоор “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг баталж, уг журам мөрдөгдөж байна.

Засгийн газраас ХХтХ-ийн 5.1.1-д заасан “харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах” бүрэн эрхийг үндэслэн 2017 оны 02 сарын 08-ны өдөр “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай” 47 дугаар тогтоол гаргасан. Гэвч Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор ЗГ-ын 2021 оны 10 сарын 13-ны өдрийн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 314 дүгээр тогтоолоор дээрх 2017 оны 47 дугаар тогтоолыг хүчингүй болгожээ.

2.1.2. ХХтХ-ийн 6 дугаар зүйл. Харилцаа холбооны салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

а) ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь харилцаа холбооны салбарын харилцаануудыг бүрэн хамарч чадаж байгаа эсэх?

ХХтХ-ийн 6 дугаар зүйлд төрийн захиргааны төв байгууллага буюу ЦХХХЯ нь 17 чиг үүргийн хүрээнд бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Ярилцлагын судалгааны хүрээнд ЦХХХЯ, ХХЗХ болон үйлчилгээ эрхлэгчидтэй уулзахад ЦХХХЯ-нд хуулиар олгосон дээрх 17 чиг үүргийн хүрээний бүрэн эрхүүд нь салбарын харилцаануудыг бүрэн хамарч, зохицуулалтыг тусгаж чадсан гэж тодорхойлсон, мөн ХХтХ-д 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшин, өрсөлдөөний өнөөгийн нөхцөл, хэрэглэгч үйлчлүүлэгчдийн хэрэглээнд нэвтэрч байгаа үйлчилгээний шинэ төрлүүдэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг тандан судалж, зохицуулалтуудыг оруулж өгсөн¹ байдаг тул ЦХХХЯ-нд хуулиар олгосон бүрэн эрхүүд нь харилцаа холбооны салбарын харилцаануудыг бүрэн хамарч чадсан гэж дүгнэлээ. Гэхдээ техник технологийн эрчимтэй хөгжлийг дагаад ирээдүйд шинэ харилцаа, шинэ технологи, инноваци үүсэж хуульд шинэ ойлголт, шинэ харилцааг зохицуулах зайлшгүй шаардлага үүсэх боломжтой юм.

б) ЦХХХЯ-ны хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал?

ХХтХ-ийн 6 дугаар зүйл, 30¹ дүгээр зүйлүүдэд зааснаар ЦХХХЯ нь 6 журам, 3 төлөвлөгөө, 1 хувь хэмжээ тогтоосон акт, 2 аргачлал батлахаар хуульчилсан байна. Үүнээс 2 журам, 1 төлөвлөгөө батлагдсан, 4 журам, 1 төлөвлөгөө, 1 хувь хэмжээ тогтоосон акт, 2 аргачлал батлагдаагүй байна.

ЦХХХЯ бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй шалтгааныг судалж үзэхэд 1-рт салбарын зарим зохицуулалтын чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд харьяалуулсан, 2-рт ХХтХ-д 2001 оноос хойш 20 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ба энэ хэмжээгээр хуулийн зохицуулалт өөрчлөгдөж байсан, 3-рт 2020 оны 11-р сараас эхэлсэн Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх зорилгоор урт хугацаанд хэрэгжүүлсэн хатуу болон хэсэгчилсэн хөл хорионы улмаас төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа саатсан, 4-рт Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж тэвчиж болох бүх зардлыг тэвчихийг бүх шатны төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт үүрэг болгосон, 5-рт төрийн захиргааны байгууллага нь технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед шинэ технологийн нэвтрэлтийг аливаа хязгаарлалтгүйгээр хурдасган дэмжих, салбар хоорондын уялдааг сайжруулах үүрэгтэй учраас шинэ технологийг журамлахаас илүүтэй салбарын мэргэжлийн оролцогчид өөрсдөө хэм хэмжээгээ тогтоох боломжийг олгосонтой холбоотой байна.

¹ ХХтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлангийн 47-р хуудас.

Хүснэгт 2. Батлагдсан болон батлагдаагүй журам, аргачлал, төлөвлөгөөний жагсаалт

№	Хуулийн үндэслэл	Батлах субъект	Баримт бичгийн нэр	Батлагдсан шийдвэрийн		Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн огноо, дугаар	Батлагдаагүй шалтгаан нөхцөл
				дугаар	огноо		
1.Харилцаа холбооны тухай хууль							
1	6.1.3.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сэргээр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;	ЦХХХЯ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сэргээр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэх журам				Төрийн захиргааны төв байгууллага нь технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед шинэ технологийн нэвтрэлтийг аливаа хязгаарлалтгүйгээр хурдасган дэмжих, салбарын үйлчилгээ эрхлэгчдийн уялдааг сайжруулах үүрэгтэй учраас шинэ технологийг журамлах, ямар нэг аргачлалаар нэвтрүүлэх боломжгүй байдал нь нөлөөлсөн. Мөн Өрсөлдөөний тухай зохицуулалт нь ЦХХХЯ, ХХЗХ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газруудад чиг үүргийн хувьд давхарддаг. Давхардлыг арилгах шаардлагатай. Харилцаа холбооны салбарын өрсөлдөөний зохицуулалтыг нэг бол Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулах эсхүл Өрсөлдөөний хуулийг
2		ЦХХХЯ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сэргээр				

			ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэх аргачлал				хэрэглэхгүйгээр ХХТХ-аар зохицуулах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай байна.
3	6.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах	ЦХХХЯ	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам	ХХМТГ А/42	2017.04.17	Бүртгэгдсэн 2017-05-03 Дугаар 3720	
4	6.1.5.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө батлах	ЦХХХЯ	Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө	ХХМТГ А/104	2018.09.11		
5	6.1.10.үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	ЦХХХЯ	Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөө				Үндсэн сүлжээтэй холбоотой заалтуудын хэрэгжилт 7-р хэсгээс үзнэ үү.
6	6.1.14.а.төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	ЦХХХЯ	Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	А/35	2022.07.06	Бүртгэгдсэн 2022-08-22 Дугаар 5928	
7	6.1.14.в.төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг	ЦХХХЯ	Төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийг шалгаруулах, тэдгээрийг дамжуулах				Уг журмын төслийг боловсруулж баталсан боловч Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгэж авахаас татгалзсан байна. Учир нь тухайн харилцааг Өргөн нэвтрүүлгийн

	дамжуулах үйлчилгээний журам		үйлчилгээний журам				тухай хуулиар зохицуулсан тул давхардал үүссэн.
8	6.1.14.г.интернэтийн дундын холболтын журам	ЦХХХЯ	Интернэтийн дундын холболтын журам				Энэхүү журам нь үйлчилгээний чанар, найдвартай ажиллагааг хангах зорилгоор үйлчилгээ эрхлэгчид дагаж мөрдөх нөхцөл шаардлага тул журмыг ХХЗХ зохицуулалтын хүрээнд батлах боломжтой. ЦХХХЯ батлахаар зохицуулсан нь оновчгүй бөгөөд практикт нийцээгүй гэж дүгнэсэн.
9	6.1.16.харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	ЦХХХЯ	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө				2019 онд Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг заалтыг баталсан боловч УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон тус хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх байнгын хорооны танилцуулга ба хуулийн төсөлд энэ заалт байгаагүй. Харин УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар энэхүү заалтыг баталсан боловч энэ заалтын зорилго, эрх ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд, ямар хүрээнд батлах тухай мэдээлэл олдоогүй бөгөөд шууд тодорхойлох боломжгүй байна. Иймд ямар субъектийн харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ямар хүрээнд батлах нь тодорхой биш, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд авч үзвэл тэдний төлөвлөгөөг батлах нь бизнесийн үйл ажиллагаанд шууд оролцох асуудал

							тул уг заалт хэрэгжээгүй байна. Хэдийгээр уг заалт хэрэгжээгүй боловч зах зээлийн зарчмаар бизнес эрхлэгчид харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн оролцоогүйгээр нэвтрүүлж ирсэн байна.
10	6.1.18. зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн Зохицуулах хорооны саналыг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох;	ЦХХХЯ	Тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох тухай				Уг заалтыг 2022 онд Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж 2023 оноос мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны 01 сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн шинэ зохицуулалт юм.
11	30 ¹ .2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн	ЦХХХЯ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам				ЦХХХЯ-аас Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9-р зүйлд заасан мэдээллийн аюулгүй байдлын аудит, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг
12			Харилцаа холбоо, мэдээллийн				

	<p>технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батална.</p>		<p>технологийн аудит хийх аргачлал</p>			<p>хамтатган боловсруулсан байсан хэдий ч УИХ-аас Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг хийж байгаатай холбогдуулан журмын төсөл болон аргачлалын төслийг тус тус батлуулаагүй байна. Зөвшөөрлийн тухай хууль 2022 онд батлагдаж 2023 оноос хэрэгжиж эхэлсэн ба уг хуулиар мэдээллийн аюулгүй байдлын аудитыг тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа болгон хуульчилсан, харин харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг хуульд тусгаагүй буюу ердийн зөвшөөрөлд тооцсон байна. Үүнээс шалтгаалан 2 журам болон аргачлалыг хамтатган батлах тохиромжтой эсэх талаар асуудал үүссэн байна. Мөн мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайлан нь нууцлалтай бол харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын тайлан нь нийтэд ил тод байхаар хуульчилсан.</p>
--	---	--	--	--	--	--

с) Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.2-т “харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах” гэж заасан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах процесстай нийцэх эсэх, нэршлийг өөрчлөх шаардлагатай эсэх?

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.1-д “энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох” гэж төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхойлсон. Эндээс үзэхэд ХХТХ-ийн 6.1.2-т заасан ... бодлого боловсруулах чиг үүрэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцнэ. Мөн түүнчлэн Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.3-т салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэж яамны нийтлэг эрхлэх асуудлын хүрээг тодорхойлсон бөгөөд тус эрхлэх асуудлын хүрээнд ХХТХ-ийн 6.1.2-т заасан бүрэн эрх агуулагдаж байна.

д) ЦХХХЯ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүд нь бусад субъектүүдийн хуулиар олгогдсон бүрэн эрхүүдтэй давхардаж байгаа эсэх?

ХХТХ-д ЦХХХЯ болон ХХЗХ-нд олгосон бүрэн эрхүүдээс үг, үсэг, агуулгын хувьд чиг үүргийн давхардалтай байж болзошгүй 3 зохицуулалт байна. Үүнд:

Хүснэгт 3. ЦХХХЯ болон ХХЗХ-ны чиг үүргийн давхардал

№	ЦХХХЯ	ХХЗХ
1	6.1.6. бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаархи бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	9.1.7.бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах;
Дүгнэлт: Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.6, мөн хуулийн 9.1.7-д бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх асуудал агуулгын хувьд ЦХХХЯ, ХХЗХ байгууллагуудад давхардуулан хуульчлаагүй байна.		
2	6.1.5.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө батлах;	9.1.9.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
Дүгнэлт: ХХЗХ нь төлөвлөгөөг боловсруулах, боловсруулсан төлөвлөгөөг ЦХХХЯ нь хянаж батлах процессыг хуульчилсан тул давхардал гэж үзэхгүй.		
3	6.1.14.в.төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам;	9.1.10.радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
Дүгнэлт: ЦХХХЯ нь радио, телевизийн нэвтрүүлгийн үйл ажиллагааг нь журамлаж өгч байгаа бол ХХЗХ нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник хангамж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй холбоотой үзүүлэлтүүдийг баталж байгаа тул давхардал гэж үзэхгүй.		

Мөн ярилцлагын судалгааны хүрээнд ЦХХХЯ, ХХЗХ болон үйлчилгээний эрхлэгчидтэй уулзахад ХХтХ-аар ЦХХХЯ болон ХХЗХ-нд олгогдсон бүрэн эрхүүд нь практикт харилцаануудыг зохицуулахад давхардал шууд үүсгэхгүй байна, харин давхардал үүсэж болзошгүй зохицуулалт нь ЦХХХЯ-ны улсын байцаагч, ХХЗХ-ны улсын байцаагчийн хяналтын хүрээ, чиг үүргийн асуудал гэж тодорхойлсон.²

Харин ХХтХ-ийн 6.1.3-т заасан “давамгай байдлаа сэргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл” батлах бүрэн эрх нь Өрсөлдөөний тухай хуулиар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт олгогдсон бүрэн эрхтэй зөрчилдөх, Өрсөлдөөний тухай хуулиар өрсөлдөөнийг зохицуулах эрх бүхий субъектээр салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу ЦХХХЯ, зохицуулагч этгээд буюу ХХЗХ-г хуульчлаагүй нь хууль хэрэглээний ойлгомжгүй байдлыг үүсгэж, зохицуулалт хийх боломжгүй, чиг үүрэг, бүрэн эрхийн давхардлыг үүсгэж байна.

Өрсөлдөөний тухай хуулийн 13.1-д **“Хуульд зааснаас бусад тохиолдолд** төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглоно.”, 13.2-т “Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага **хуульд зааснаас бусад тохиолдолд** дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 13.2.1.аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан; 13.2.2.аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнээ нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан; 13.2.3.тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн; 13.2.4.бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн; 13.2.5.зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн; 13.2.6.аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг бусад байгууллага, аж ахуй эрхлэгчид зээлээр олгоход чиглэсэн; 13.2.7.аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн.” гэж хуульчилжээ. ХХтХ-ийн 6.1.3-т ЦХХХЯ-нд давамгай байдлаа сэргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл батлах, 9.1.6-д ХХЗХ-нд харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах гэсэн ерөнхий бүрэн эрхийг тусгасан болохоос уг чиглэл болон журамд ямар үйл ажиллагаа, зохицуулалт хамаарахыг нарийвчилж тусгаагүйгээс Өрсөлдөөний тухай хуулийн дээрх заалтад заасан хуульд зааснаас бусад тохиолдол гэдэгт хамаарах эсэх нь тодорхойгүй, ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Өрсөлдөөний тухай хуулийн 6.3-т “Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй.” гэж заасан хэдий ч энэ нь зөвхөн зүй ёсны монополь байдалтай үйлчилгээ эрхлэгчид хамаарах зохицуулалт бөгөөд ердийн үйлчилгээ эрхлэгчдэд хамаарахгүй заалт тул ХХтХ-ийн 6.1.3, 9.1.6-д заасан бүрэн эрхүүд нь

² Уг асуудлыг Салбарын улсын байцаагчийн асуудал 5-р хэсгээс үзнэ үү.

ШӨХТГ-тай чиг үүргийн давхардлыг үүсгэсэн, зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж дүгнэж байна.

е) Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.в дэх заалт нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа эсэх?

ХХтХ-д 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт өөрчлөлтөөр ХХтХ-ийн 6.1.14.в-д “төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам батлах” бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хуульчилж өгсөн байна. Харин радио, телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэх үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталжээ. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7-р зүйлд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх нийтлэг харилцааг зохицуулсан ба 29-р зүйлийн 29.1.5-д төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулах бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, 30-р зүйлийн 30.1.7.б-д өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг, 30.1.7.в-д олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулах бүрэн эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус олгожээ. Эндээс үзэхэд Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.в дэх заалтад тусгасан харилцааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулсан, давхардал үүссэн байна.

ф) Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “баримтлах чиглэл” батлах эрхтэй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай зөрчилдөх эсэх?

ХХтХ-ийн 6.1.3-т “харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сөргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах” бүрэн эрх ЦХХХЯ-нд олгогдсон байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.6, 6.7 дахь хэсэг, заалтуудад зааснаар чиглэл батлах бүрэн эрх нь УИХ-д олгогдсон тул ХХтХ-ийн 6.1.3-т заасан баримтлах чиглэл батлах бүрэн эрх нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дээрх заалтуудтай зөрчилдөж байх тул ХХтХ-ийн 6.1.3-т заасан ЦХХХЯ-нд чиглэл батлах хэсгийг хасах шаардлагатай гэж дүгнэж байна.

2.1.3. ХХТХ-ийн 8 дугаар зүйл. Харилцаа холбооны зохицуулах хороо

- ХХЗХ-ны эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлсон байдал?

Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр 1997 онд элссэн. Монгол Улс ДХБ-д гишүүнээр элссэнээр худалдаатай холбоотой дотоодын 30 гаруй хууль тогтоомжийг тус байгууллагын зарчим, дүрэм, журамд нийцүүлэн шинэчилсэн буюу шинээр гаргаж, худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байна.³ Үүний нэг нь чөлөөт зах зээлийг хөгжүүлэх зорилгоор төрөөс хараат бус, бие даасан зохицуулах байгууллагыг байгуулах үүрэг хүлээсэн нь ХХЗХ байгуулагдах үндэс суурь нь болжээ.

Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх зүйн үндсийг тодорхойлсон холбогдох хуулиудад төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдээр салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага зэрэг этгээдүүдийг тодорхойлсон ба зохицуулах байгууллага, зохицуулах хороо гэсэн субъект тусгагдаагүй байдаг. Үүнээс улбаалан ХХЗХ-г төрийн байгууллага гэж үзэх боломжгүй, ХХЗХ-ны ажилтнууд нь төрийн албан хаагчид биш байдаг хэдий ч төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг этгээд мөн юм. ХХЗХ-ны эрх зүйн байдлыг ХХТХ-ийн 8 дугаар зүйлд хуульчилж, 9 дүгээр зүйлд бүрэн эрхийг нь тогтоосон. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.3-т “захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд,” нь захиргааны байгууллага гэж ойлгоно гэж хуульчилсны дагуу ХХЗХ-г захиргааны чиг үүргийг хуулийн үндсэн дээр шилжүүлж авсан этгээд, захиргааны байгууллага гэж үзнэ. Иймд ХХЗХ нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагын эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

Ярилцлагын судалгааны явцад холбогдох хүмүүстэй уулзахад нэг хэсэг нь ХХЗХ-ны эрх зүйн байдал нь тодорхойгүй тул эрх зүйн байдлыг нь өөрчилж хэрэгжүүлэгч агентлаг болгох хэрэгтэй, нөгөө хэсэг нь бие даасан, хараат бус зохицуулах байгууллагыг энэ хэвээр нь хадгалах хэрэгтэй гэсэн эсрэг тэсрэг байр суурийг илэрхийлж боловч үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүд бүгд бие даасан, хараат бус зохицуулах байгууллагыг энэ хэвээр нь хадгалах саналтай байсныг дурдах нь зүйтэй.

Олон улсын харилцаа холбооны салбарын чиг хандлагаар зохицуулах байгууллага нь бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхээр нь тухайн орны зах зээлийг либералчлагдсан гэж үздэг буюу бие даасан, хараат бус байдал нь тухайн орны зах зээлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлт болсон байна. Мөн Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд чөлөөт зах зээлийг хөгжүүлэх, чөлөөт зах зээлийг хөгжүүлэхэд бие даасан,

³<https://mfa.gov.mn/wp-content/uploads/2021/02/4.-%D0%94%D1%8D%D0%BB%D1%85%D0%B8%D0%B8%CC%86%D0%BD-%D1%85%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B4%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B-%D0%B1%D0%B0%D0%B8%CC%86%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D0%BB%D0%B0%D0%B3%D1%83%D1%83%D0%B4.pdf>

хараат бус зохицуулах байгууллагыг байгуулах гишүүний үүргээ биелүүлж, ХХЗХ-ны эрх зүйн байдлыг хадгалж ирсэн гэж үзэж байна.

- ХХтХ-ийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилохоор заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эсэх?

Ярилцлагын судалгааны явцад зарим оролцогчдоос ХХтХ-ийн 8.3-т ХХЗХ-ны дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй, харин тус хуулийн 20 дугаар 19 дэх хэсэгт заасан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлыг шийдвэрлэж байгаа тул дээрх ХХтХ-ийн 8.3 нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дээрх хэсэгтэй зөрчилдөж байж болзошгүй талаар дурдсан байдаг. Үүнийг судалж үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1-д “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэж заасан байдаг. Иймд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрхлэх асуудлаар хязгаарлагдахгүй, хуулиар ЗГ-т олгогдсон бүх бүрэн эрх, чиг үүрэг нь Ерөнхий сайдтай шууд хамааралтай юм. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээний ажлыг энэ хуулиар, **тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна.**”, мөн тус хуулийн 23 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийг хуульчилсан ба бүрэн эрхүүдийн 9-д “хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж заасан ба ХХтХ-ийг бусад хууль буюу хууль тогтоомж гэж үзнэ. Иймд ХХтХ-ийн 8.3 дахь хэсэг нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 19 дэх хэсгүүдтэй зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

2.1.4. ХХтХ-ийн 9 дүгээр зүйл. ХХЗХ-ны бүрэн эрх

а) ХХЗХ-нд хуулиар олгогдсон бүрэн эрхүүдийн хэрэгжсэн байдал?

ХХтХ-ийн 9 дугаар зүйлд ХХЗХ нь 17 төрлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зааснаас 9 журам, 1 төлөвлөгөө, 1 хувь хэмжээ тогтоосон акт, 1 аргачлал, 1 нөхцөл, шаардлага батлахаар хуульчилсан байна. ХХЗХ нь хуульд заасан дээрх бүх журам, төлөвлөгөө, хувь хэмжээ тогтоосон акт, аргачлал, нөхцөл, шаардлагыг боловсруулж баталсан байна.

Иймд ХХЗХ нь ХХтХ-аар олгогдсон бүрэн эрхүүдийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж байна гэж дүгнэлээ.

2.2.САЛБАР ХООРОНДЫН ЗОХИЦУУЛАЛТ

<p style="text-align: center;">Үнэлэх хэсэг</p>	<p>6¹дүгээр зүйл. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх салбар хоорондын үйл ажиллагаа</p> <p>6¹.1.Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байна.</p> <p>6¹.2.Дараах байгууллага харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна:</p> <p>6¹.2.1.төрийн захиргааны төв байгууллага, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхгүй бол төрийн захиргааны байгууллага;</p> <p>6¹.2.2.Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;</p> <p>6¹.2.3.Шүүхийн ерөнхий зөвлөл;</p> <p>6¹.2.4.Улсын ерөнхий прокурорын газар.</p> <p>6¹.3.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.</p> <p>6¹.4.Салбар хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх бодлого, төлөвлөлтийн асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>6¹.5.Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний дараагийн жилийн эхний улиралд багтаан харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.</p> <p>6¹.6.Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтэд харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу үнэлгээ хийнэ.</p>
<p style="text-align: center;">Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчим хэрхэн хангагдаж байна вэ? • Салбар хоорондын харилцаанд нэмж тусгах шаардлагатай субъект байгаа эсэх? • Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөл?

а) Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчим хэрхэн хангагдаж байна вэ?

ХХТХ-ийн 6¹.1-т “Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байна.” гэж заажээ. Энэхүү зохицуулалтыг хуулинд 2019 оны 05 сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн ба уг 2019 оны хуулийн үзэл баримтлалд “салбар бүрд мэдээлэл, харилцаа холбооны технологи, үйлчилгээ нь харилцан уялдаагүй, нэгдсэн бодлогогүй, асар их хэмжээний хөрөнгө оруулалтын давхардалтай нэвтэрч байна. Жишээлбэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 онд хийсэн судалгаагаар төрийн захиргааны 10 байгууллага дээр мэдээллийн технологийн чиглэлээр гадаад зээлийн хэрэгжих болон хэрэгжиж байгаа төслүүдийг авч үзэхэд 200 гаруй сая ам.долларын төсөвт өртөг бүхий 17 төсөл арга хэмжээ байгаагаас 9 төслийн явц удаашралтай, зээлийн ашиглалтын хувь бага байна. Энэ нь улс орны хэмжээнд мэдээллийн технологийн төслийн нэгдсэн удирдлага байхгүй, энэ чиглэлээр байгууллага хоорондын ажлын уялдаа сул, улс орны өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд төслүүдийг чиглүүлэх чиг үүрэг орхигдсонтой холбоотой байна”⁴ гэж дурджээ.

Дээрх хэрэгцээ шаардлагын хүрээнд бусад салбаруудын хэрэгжүүлж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдэд нэгдмэл бодлого, төлөвлөлтөд хяналт тавих, чиглүүлэх чиг үүрэг, бүрэн эрх ЦХХХЯ-нд ХХТХ-ийн 6¹.2, 6¹.3, 6¹.5, 6¹.6 хэсгүүдээр олгогдсон байна.

Гэвч Монгол Улсад улсын болон орон нутгийн төсөв, гадаад орнууд, олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт төсөл хөтөлбөр, үүнээс харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл байхгүй байгаагаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдмэл бодлого, төлөвлөлтийг бий болгох, хөгжүүлэх боломжгүй байдалтай байна. Жишээлбэл:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтад Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт⁵ батлагдсан байгаа ба уг жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээг 2023 онд 2,686,015,300,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Дээрх төсөл, арга хэмжээний хэд нь харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбоотой төсөл арга хэмжээ болох нь тодорхойгүй байна.
2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь 2022 оны байдлаар гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр 18⁶ төсөл хэрэгжүүлж байгаагаас хэд нь харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбоотой төсөл хөтөлбөр болох нь тодорхойгүй байна.

⁴ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын практик шаардлагын 3 дахь хэсэг

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759750505231&showType=1>

⁶ <https://www.met.gov.mn/pages/show/odoo-heregzhizh-bajгаа-t-sl-dijn-talaarh-medeelel/mn>

Энэ нь харилцаа холбооны салбарт салбар хоорондын зохицуулалт байх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа бөгөөд ХХтХ-ийн 6¹ дүгээр зүйлд заасан салбар хоорондын зохицуулалт нь зайлшгүй байх ёстой зохицуулалт гэж дүгнэж байна. ХХтХ-ийн 6^{1.1}-д заасан нэгдмэл бодлого, төлөвлөлтийг бий болгох, хяналт тавихын тулд харилцаа холбооны салбараас бусад салбар болон байгууллагуудын харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн бүртгэл, мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, мэдээллийн санг хөгжүүлэх шаардлагатай байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.26-д мэдээлэл хадгалагч нь “төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;”-г ил тод, нээлттэй байлгах үүрэг хүлээсэн, мөн тус хуулийн 29 дүгээр зүйлд нийтийн мэдээллийн систем байгуулахаар тусгасан ба уг системийн гол зохицуулагч нь ЦХХХЯ байхаар тус тус хуульчилсан тул дээрх шаардлагатай уялдаж ХХтХ-ийн 6^{1.1}-д заасан нэгдмэл бодлого, төлөвлөлт хэрэгжих бүрэн боломж бий болсон байна.

b) Салбар хоорондын харилцаанд нэмж тусгах шаардлагатай субъект байгаа эсэх?

ХХтХ-ийн 6^{1.2}-т “Дараах байгууллага харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна: төрийн захиргааны төв байгууллага, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхгүй бол төрийн захиргааны байгууллага; Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага; Шүүхийн ерөнхий зөвлөл; Улсын ерөнхий прокурорын газар.” гэж тодорхойлж хуульчилжээ.

Ярилцлагын судалгааны хүрээнд холбогдох хүмүүстэй уулзахад бусад салбарын байгууллагуудын гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдмэл бодлого, төлөвлөлттэй уялддаггүй гэдгийг дурдсан байдаг. Иймд 6^{1.2}-т заасан байгууллагуудын гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг уялдуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

c) Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар яамнаас саналыг авч байгаа эсэх?

ХХтХ-ийн 6^{1.3}-т “Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.” гэж үүрэгжүүлж, зарчмыг тогтоосон байна.

Ярилцлагын судалгааны хүрээнд холбогдох хүмүүстэй уулзахад дээрх зохицуулалтыг бусад салбарын байгууллагуудын харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргах байдлаар хэрэгжүүлж

байгаа гэдгийг мэдэгдсэн бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар нийт 6 төсөл, хөтөлбөрүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргасан нь дээрх заалт хэрэгжиж эхэлж байгааг харуулж байна.

d) Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөл?

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд хийсэн дүгнэлтүүдээс үзэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх хуулийн зохицуулалт бүрэн бүрдээгүй гэж дүгнэж байгаа бөгөөд ийнхүү хуулийн зохицуулалт хангалтгүй байгаа нь дараах нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна. Үүнд:

1. Бусад салбарын төрийн байгууллагуудад ХХтХ-ийн мэдлэг дутмаг.
2. ХХтХ-ийн 6^{1.2}, 6^{1.3}, 6^{1.5}, 6^{1.6}-д тус тус заасан ЦХХХЯ-тай хамтран зохион байгуулах, санал авах, хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх үүргээ биелүүлээгүй бусад салбарын төрийн байгууллагын холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулиар сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалт тодорхой бус байна. /ХХтХ-ийн 32.1, ТАтХ-ийн 37, 48/.
3. Гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, түүний төслийн нэгжийг салбар хоорондын харилцаанд оролцогчоор хуульчлаагүй.

2.3. ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС ГАЗРЫН ХЭМЖЭЭ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС ГАЗРЫН ДАВХАРДАЛ

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>28 дугаар зүйл.Зурвас газар 28.1.Монгол Улсын газрын нэгдмэл сангаас холбооны сүлжээнд зориулан олгосон газар, орон зайг харилцаа холбооны хамгаалалтын зурвас газар гэнэ. Хамгаалалтын зурвас газар нь дараахь хэмжээтэй байна: 28.1.2.кабелийн шугамаас тал бүртээ 5 метр;</p> <p>29 дүгээр зүйл.Зурвас газарт тавих хяналт 29.1.Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газар үйлчлэгчийн хяналтад байна. 29.3.Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 29.3.1.барилга, гэр, хашаа барих, мод тарих; 29.3.2.кабель гэмтээж болох зүйл хаях, химийн идэмхий бодис асгах; 29.3.3.зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр ачаатай тээврийн хэрэгслээр агаарын баганат шугамыг хөндлөн гарах.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Үйлчлэгчид хамгаалалтын зурвас газрыг газрын дуудлага худалдаагаар олгож буй нь сөрөг үр дагавартай байгаа эсэх? • Газрын дуудлага худалдааны анхны үнэ тогтоох эрх зүйн зохицуулалт нь тодорхой байгаа эсэх? • Үйлчлэгч хамгаалалтын зурвас газарт хяналтаа хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байгаа эсэх? • Хамгаалалтын зурвас газрын хэмжээ үйлчлэгч нарт хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх?

- Үйлчлэгчид хамгаалалтын зурвас газрыг газрын дуудлага худалдаагаар олгож буй нь сөрөг үр дагавартай байгаа эсэх?

Харилцаа холбооны сүлжээ, байгууламж байгуулах ажил нь төр засгийн хувьд эдийн засаг болон нийгмийн өндөр ач холбогдолтой боловч бизнес эрхлэгчдийн хувьд санхүүжилт ихээхэн шаарддаг учраас тодорхой нэг чиглэлд ялангуяа орон нутаг, сум, баг руу уралдаж сүлжээ, байгууламж байгуулах шаардлага төдийлөн гардаггүйгээс газар эзэмших, ашиглах эрхийг нээлттэй дуудлага худалдаагаар авах зохицуулалт нь практикт нийцэхгүй, харин сөрөг үр дагавартай байна.

Тодруулбал, Харилцаа холбооны зурвас газар нь Газрын тухай хуулийн 13.1-т заасны дагуу зам, шугам сүлжээний газарт хамаарагдана.⁷ Газрын тухай хуулийн 27.1⁸ болон 33.1.2⁹-т заасны дагуу үйлчлэгчид нь харилцаа холбооны сүлжээ суурилуулах газраа газрын дуудлага худалдаагаар авах шаардлагатай болдог. Үүний тулд тухайн сүлжээ байгуулах орон нутгийн газрын албанд хүсэлт гаргах, хүсэлтийн дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, дуудлага худалдаа зохион байгуулах, дуудлага худалдаанд шалгарсан нөхцөлд гэрээ байгуулах үе шатуудыг дамждаг. Гэвч эдгээр үе шатууд нь хамгийн багадаа 1 жил, хэрэв сүлжээ тавих газар нь олон аймаг, сумын нутаг дамнасан бол үүнээс илүү хугацаа шаардаж байна.

Мөн түүнчлэн Газрын тухай хуулиар газрын дуудлага худалдаанд аливаа сонирхогч этгээд оролцох эрх нээлттэй байгаа нь харилцаа холбооны сүлжээ байгуулахгүй боловч газрын дуудлага худалдаанаас ашиг олох сонирхолтой этгээдэд боломж олгох сөрөг үр дагавар бий болгож байна. Тухайлбал газрын дуудлага худалдаанд үнийг зохиомлоор өсгөж байснаа мөнгө санал болговол газрын үнэ өсгөхөө болих санал тавих, газрын дуудлага худалдаагаар газрыг авсны дараа үйлчилгээ эрхлэгчид өндөр үнээр худалдах санал тавих боломжийг бүрдүүлж байна.

- Газрын дуудлага худалдааны анхны үнэ тогтоох эрх зүйн зохицуулалт нь тодорхой байгаа эсэх?

Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 208-р тушаалаар Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал, итгэлцүүрийг баталсан боловч үүнд харилцаа холбооны сүлжээ байгуулах газрын дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал, итгэлцүүр, суурь үнийг батлаагүй байна.

⁷ Газрын тухай хуулийн 13.1.Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.

⁸ Газрын тухай хуулийн 27.1.Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.


⁹ Газрын тухай хуулийн 33.1.2.энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.

Энэхүү тодорхой бус байдлаас шалтгаалан практикт шугам, сүлжээний газрын дуудлага худалдааны анхны үнийг хамгаалалтын зурвас газрын нийт талбайн хэмжээгээр тооцох зарчим баримталж байна. Бүх төрлийн шугам, сүлжээний газрын дуудлага худалдаанд талбайн суурь үнийг авахдаа худалдаа, үйлчилгээний ангилалд оруулж Засгийн газрын 2018 оны 182 дугаар “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолыг мөрдлөг болгон тухайн орон нутагт өөр өөрөөр шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, худалдаа үйлчилгээний газрын суурь үнэ нь “га”-гаар хэмжигддэг бөгөөд хэд хэдэн сум сууринг дамжиж байгуулагддаг харилцаа холбооны кабель шугамыг энэ ангилалд оруулснаар дуудлага худалдааны үнэ /км*зурвас газрын өргөн*суурь үнэ/ маш өндөр тогтоогдох нөхцөл бий болдгоос шалтгаалан зарим газар дуудлага худалдаанд орохыг шаардаж байхад зарим газар газраа шууд олгодог. Иймд энэхүү шугам, сүлжээний газрын дуудлага худалдааны анхны үнийг тогтоож байгаа практик нь эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байгааг харуулж байна.

- Үйлчлэгч хамгаалалтын зурвас газарт хяналтаа хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байгаа эсэх?

ХХТХ-ийн 29.1-д заасны дагуу үйлчлэгч нь харилцаа холбооны хамгаалалтын зурвас газарт хяналт тавих үүрэг хүлээсэн. Энэхүү хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд харилцаа холбооны шугам болон зурвас газрын мэдээллийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн Газрын кадастрын систем /LM систем/-д бүрэн оруулах нь чухал ач холбогдолтой. Гэвч Газрын кадастрын системийн програм нь хамгаалалтын зурвас газрын бусад инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвастай давхацсан хэсгийг бүртгэж авдаггүй тул харилцаа холбооны хамгаалалтын зурвас газрын мэдээлэл Газрын кадастрын систем дээр бүрэн орохгүй тохиолдол гардаг байна.

Зураг 1. Говьсүмбэр аймгийн Баянтал сум



Зураг 1-ээс харахад, Говьсүмбэр аймгийн Баянтал сумын нутагт харилцаа холбооны 2 зурвас газар байгаа боловч бусад дэд бүтцийн зурвас газартай давхацсан хэсэгт мэдээлэл ороогүй байгаа нь тодорхой харагдаж байна. Үүний улмаас дэд бүтэц, инженерийн барилга байгууламж байгуулах этгээдүүд харилцаа холбооны сүлжээг гэмтээх явдал гардаг байна.

d) Хамгаалалтын зурвас газрын хэмжээ үйлчлэгч нарт хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх?

ХХтХ-ийн 28.1.2-т зааснаар хамгаалалтын зурвас нь кабелийн шугамаас тал бүртээ 5 метр байна гэж заасан. Энэхүү хэмжээ нь кабелийн шугамын аюулгүй байдлын талаасаа үйлчлэгч нар хүлээн зөвшөөрөгдөж байгаа боловч тухайн орон нутгийн инженерийн дэд бүтэц, шугам, сүлжээ байгуулах орон зайн багтаамж, газрын нэгдмэл сангаас бусдад олгосон газрын байршилаас хамаарч кабелийн шугамаас тал бүртээ 5 метрээс дотогш татах тохиолдлууд үүсч байна. Жишээлбэл: Говьсүмбэр аймгийн Баянтал сумын нутагт Мобинет ХХК болон Жемнэт ХХК-иуд кабелийн шугам суурилуулсан боловч Мобинет ХХК-ийн хамгаалалтын тал бүртээ 5 метр өргөн, Жемнэт ХХК-ийн компанийн хамгаалалтын зурвас тал бүртээ 1 метр өргөнтэй байна. Иймд харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хамгаалалтын зурвас газрын хэмжээ кабелийн шугамаас тал бүртээ 5 хүртэлх метр байх нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

2.4. ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АУДИТ

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>30¹дүгээр зүйл.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит</p> <p>30¹.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.</p> <p>30¹.2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батална.</p> <p>30¹.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.</p> <p>30¹.4.Энэ хуулийн 30¹.3-т заасан жагсаалтад хамаарах байгууллага хоёр жил тутам харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлангаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, тайланг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.</p> <p>30¹.5."Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит" гэж тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, техникийн шийдэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь байгууллагын стратегийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлж, стандартад нийцэж байгаа эсэхийг хөндлөнгийн этгээдээс тогтоож, дүгнэлт, зөвлөмж гаргах хараат бус үйл ажиллагааг</p>
----------------------------	--

	<p>ойлгоно.</p> <p>30¹.6.Төрийн аудитын байгууллагаас захиргааны байгууллагын үйл ажиллагаанд аудит хийхтэй холбогдсон харилцаанд энэ зүйл хамаарахгүй.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит байх шаардлагатай эсэх? • Мэдээллийн аюулгүй байдлын аудит, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит 2 нь давхардсан аудит эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх авсан хуулийн этгээд байгаа эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох нь Зөвшөөрлийн тухай хуульд нийцэж байгаа эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал батлагдсан эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалт ЗГ-аас баталсан эсэх? • Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан захиргааны байгууллага байгаа эсэх?

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит байх шаардлагатай эсэх?

ХХтХ-ийн 30¹.5-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит” гэж тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, техникийн шийдэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь байгууллагын стратегийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлж, стандартад нийцэж байгаа эсэхийг хөндлөнгийн этгээдээс тогтоож, дүгнэлт, зөвлөмж гаргах хараат бус үйл ажиллагааг ойлгоно.” гэж тодорхойлжээ. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит нь 2019 оны 05 сарын 30-ны өдрийн хуулиар ХХтХ-д нэмж орсон шинэ зохицуулалт юм.

2019 оны 05 сарын 30-ны өдрийн хуулийн үзэл баримтлалд “Монгол Улсад мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж, аливаа байгууллагын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг, үйлчилгээний чухал хэрэгсэл болж байгаа хэдий ч мэдээллийн технологийн ашиглалт, хэрэглээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна. Нөгөө талаар, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, шийдлийг авч ашиглах нь хөрөнгө оруулалт ихээр шаардахын зэрэгцээ нэвтрүүлсэн технологи, худалдаж авсан систем нь байгууллагын үйл ажиллагааг бүрэн дэмжин, стратегийн зорилт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхэд аливаа байгууллага бүрэн итгэлтэй байх эрэлт хэрэгцээ үүсээд байна. Эдгээр эрэлт хэрэгцээг мэдээллийн технологийн аудитын үйлчилгээгээр хангадаг боловч манай улсад энэ чиглэлийн харилцааны эрх зүйн орчин бүрэлдээгүй байна”¹⁰ гэж дурджээ. Энэ нь ХХтХ-д харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын зохицуулалт байх

¹⁰ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын практик шаардлагын 4 дэх хэсэг

хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа тул ХХТХ-ийн 30¹ дүгээр зүйлд заасан харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит нь зайлшгүй байх шаардлагатай зохицуулалт гэж дүгнэж байна.

- Мэдээллийн аюулгүй байдлын аудит, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит 2 нь давхардсан аудит эсэх?

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.10-д “мэдээллийн аюулгүй байдлын аудит” гэж кибер аюулгүй байдлын хууль тогтоомж, холбогдох журам, стандартад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус хөндлөнгийн мэргэжлийн үйл ажиллагааг;”, ХХТХ-ийн 30^{1.5}-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит” гэж тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, техникийн шийдэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь байгууллагын стратегийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлж, стандартад нийцэж байгаа эсэхийг хөндлөнгийн этгээдээс тогтоож, дүгнэлт, зөвлөмж гаргах хараат бус үйл ажиллагааг ойлгоно.” гэж тус тус ялгаатайгаар тодорхойлжээ.

Ярилцлагын судалгааны хүрээнд холбогдох хүмүүсээс тодруулахад мэдээллийн аюулгүй байдлын аудит нь мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах программ хангамж тал руу чиглэсэн байдаг бол харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит нь техник хангамж, программ хангамж аль алиныг нь хамарсан өргөн хүрээний ойлголт гэж тодорхойлсон болно.

Мөн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9.6-д “Энэ хуулийн 9.1-д заасан хуулийн этгээд болон мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайлан, мэдээллийг хүлээн авсан холбогдох байгууллага, албан тушаалтан нууцлалыг чандлан хадгалж, задруулахгүй байх үүрэг хүлээнэ.” гэсэн зохицуулалттай бол ХХТХ-ийн 30^{1.4}-т “Энэ хуулийн 30^{1.3}-т заасан жагсаалтад хамаарах байгууллага хоёр жил тутам харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлангаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, тайланг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.” гэсэн эсрэг зохицуулалт бүхий аудитууд юм.

Иймд дээрх 2 аудит нь тухайн байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон хамрах хүрээний хувьд давхардаж байгаа боловч хяналтын объект, зорилгын хувьд өөр тул давхардал үүсээгүй гэж дүгнэж байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх авсан хуулийн этгээд байгаа эсэх?

Харилцаа холбооны тухай хуулийн 30¹ дүгээр зүйлийн 30^{1.1}-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.” гэж заасан. Гэвч Харилцаа холбооны тухай хуульд 2019 оны 05 сарын 08-ны өдөр хуулийн зохицуулалт нэмэгдэж орсон, 2021 оны 11 сарын 12, 2021 оны 12 сарын 17-ны хуулиар өөрчлөлт оруулж, мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЦХХХЯ-наас

харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх авсан хуулийн этгээд байхгүй байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох нь Зөвшөөрлийн тухай хуульд нийцэж байгаа эсэх?

УИХ-аас 2022 онд батлагдаж 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны чиглэлүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх үйл ажиллагаа багтаагүй тул Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.5, 1.6 дахь хэсгүүдэд заасан “хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахгүй байх”, “энэ хуульд заасан зөвшөөрөл олгох” зарчимтай зөрчилдөж байна.

Гэхдээ Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 3-т “Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.” гэж заасан байна. Дээрх хуулийн зохицуулалт нь “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж иш татаагүй “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж хуульчлагдсан байх тул УИХ-аас батлан гаргасан бүхий л хуулийг хамруулан ойлгоно. Иймд ХХТХ-ийн 30¹.1-д ЦХХХЯ нь аудит хийх хуулийн этгээдэд эрх олгохоор хуульчилсан тул Зөвшөөрлийн тухай хуулийн дээрх зарчмуудтай зөрчилдөж байгаа хэдий ч хуульд заасан тохиолдолд хамаарах тул Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдөөгүй байна.

Гэсэн хэдий ч ХХТХ-ийн 30¹.1-д эрх олгож байгаа үйлдэл нь Захиргааны ерөнхий хуулийн 37.1-д заасан захиргааны акт, мөн Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл олгох нэг хэлбэр гэж үзэх тул Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2-т заасан энгийн зөвшөөрлүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг оруулах зайлшгүй шаардлагатай байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал батлагдсан эсэх?

Харилцаа холбооны тухай хуулийн 30¹ дүгээр зүйлийн 30¹.2-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батална.” гэж заасан байна. Гэвч бодит байдал дээр Харилцаа холбооны тухай хуульд 2019 оны 05 сарын 08-ны өдөр хуулийн зохицуулалт нэмэгдэж орсон, 2021 оны 11 сарын 12, 2021 оны 12 сарын 17-ны хуулиар өөрчлөлт оруулж, мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд ЦХХХЯ нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг батлаагүй байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалт ЗГ-аас баталсан эсэх?

Харилцаа холбооны тухай хуулийн 30¹ дүгээр зүйлийн 30^{1.3}-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.” гэж заасан байна. Гэвч одоогийн байдлаар Харилцаа холбооны тухай хуульд 2019 оны 05 сарын 08-ны өдөр хуулийн зохицуулалт нэмэгдэж мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд ЗГ-аас харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг батлаагүй байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан захиргааны байгууллага байгаа эсэх?

Дээрх нөхцөл байдлууд болох ЗГ-аас жагсаалт батлаагүй, аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, аудит хийх аргачлал батлагдаагүйгээс ЦХХХЯ аудит хийх хуулийн этгээдэд эрх олгоогүй, бүртгээгүй байх тул харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан захиргааны байгууллага байхгүй байна. Дээрх дүгнэлтүүдээс нэгтгэн дүгнэвэл ХХТХ-ийн 30¹ дүгээр зүйлд заасан харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын зохицуулалт хангалтгүй хэрэгжсэн байна гэж дүгнэлээ.

2.5. САЛБАРЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АСУУДАЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>Хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-т “Зохицуулах хороонд харилцаа холбооны улсын байцаагч ажиллана.”</p> <p>30 дугаар зүйл.Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлчилгээнд тавих хяналт</p> <p>30.1.Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд улсын байцаагч хяналт тавина.</p> <p>30.2.Улсын байцаагч Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.2.1.харилцаа холбооны болон радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлт, тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтийг хянан шалгах;</p> <p>30.2.2.харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлд мөрдвөл зохих технологийн горим, тогтоосон стандарт, техникийн нөхцөл болон энэ хуульд заасан бусад шаардлагын биелэлтийг шалгах;</p> <p>30.2.3.тусгай зөвшөөрөлгүйгээр харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлсэн, бүртгэлгүйгээр радио давтамж ашигласан тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох.</p> <p>30.3.Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харилцаа холбооны улсын байцаагч ажиллаж болно.</p> <p>30.4.Зохицуулах хороо болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажиллах улсын</p>
----------------------------	---

	<p>байцаагчийн эрхийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу олгоно.</p> <p>31 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх</p> <p>31.1.Арбитрын хэлэлцээртэй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.</p> <p>31.2.Энэ хуулийн 31.1-д зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Зохицуулах хороо, салбар зөвлөл шийдвэрлэнэ.</p> <p>31.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь энэ хуулийн 31.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Төрийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн эрх үүрэг хэрэгжиж байгаа байдал? • Салбарын улсын байцаагчийн үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой эсэх? • ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг болон түүний улсын байцаагчийн өргөдөл, гомдол, мэдээллээр хяналт шалгалт явуулах чиг үүргээс зааглагдсан эсэх? • Улсын байцаагчийн тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь ХХЗХ-ны энэ талаарх бүрэн эрхээс ялгагдаж байгаа эсэх?

a) Төрийн хяналт, шалгалтын улсын байцаагчийн эрх үүрэг хэрэгжиж байгаа байдал?

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх , ...”, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4. “Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг эрхлэх асуудлынх нь хүрээнд хамаарах төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно.” гэсний дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яам хяналт шалгалт хийх эрхээ Харилцаа холбооны зохицуулах хороонд шилжүүлж болох бөгөөд хяналт шалгалт хийх эрхээ шилжүүлэх эсэх нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын бүрэн эрхийн асуудал байна.

b) Салбарын улсын байцаагчийн үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой эсэх?

Салбарын төрийн хяналт шалгалтын улсын байцаагч нь аль нэг байгууллагад ажиллаж байгаагаас үл хамаараад шаталсан зохион байгуулалттай, нэгдмэл удирдлагатай, ижил чиг үүргийг хэрэгжүүлж байдаг. Гэхдээ хуулийн зохицуулалтыг үзвэл ХХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.7-т “Зохицуулах хороонд харилцаа холбооны

улсын байцаагч ажиллана.” гэж, ХХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харилцаа холбооны улсын байцаагч ажиллаж болно.” гэж тус тус заасан байна. Үүнээс үзвэл ХХЗХ болон ЦХХХЯ-нд тус тусдаа чиг үүрэг бүхий улсын байцаагч ажилладаг гэж ойлгогдож болохоор байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон салбарын хуулиудаар нэг салбарын улсын байцаагчид ижил чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байх ба Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д “Хяналт шалгалтын байгууллагад улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.” гэж заасан байх тул Харилцаа холбооны тухай хуульд давхардуулан “Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харилцаа холбооны улсын байцаагч ажиллаж болно.”, “Зохицуулах хороонд харилцаа холбооны улсын байцаагч ажиллана.” гэж заах шаардлагагүй юм.

Салбарын улсын байцаагчийн үйл ажиллагааны уялдаа холбоо нь практикт хэрэгжихдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7”хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх.”, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1-хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 1.5 ”Хяналт шалгалтын үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1-д заасан зарчмыг баримтлахаас гадна хяналт шалгалтад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, хяналт шалгалтын бүртгэлийг цахим хэлбэрээр нэгтгэн бүртгэх, удирдах бодлого баримтална.”, 1.6.”Хяналт шалгалтын нэг объектод хэд хэдэн хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийх бол эдгээр байгууллага хяналт шалгалтыг хамтран төлөвлөж, зохион байгуулах зарчмыг баримтална.”, 3.8.2.”хяналт шалгалтыг хамтран хийх тохиолдолд холбогдох салбарын улсын ерөнхий байцаагч нартай зөвлөлдөн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага, хамтран оролцох байгууллагыг тодорхойлох;” дахь заалтуудыг баримтлан хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн www.shilenkhyanalт.gov.mn системд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хамтран төлөвлөж хэрэгжүүлж ирсэн байна. Харин төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг системд үүсгэхэд шалгуулагч давхардаж байгаа эсэхийг систем хянадаг бөгөөд байцаагчид хамтран хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. Өөрөөр хэлбэл нэг объектод хэд хэдэн хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийх бол эдгээр байгууллага хяналт шалгалтыг хамтран хийх боломжтой буюу үйл ажиллагааныхаа уялдаа холбоог хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн www.shilenkhyanalт.gov.mn системээр дамжуулан хангадаг байна.

Харин МХЕГ /хуучнаар/ нь Зам тээврийн хөгжлийн яам, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах зэрэг төрийн тусгай хамгаалалттай байгууллагуудад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т заасныг үндэслэн хяналт шалгалт хийх эрхээ шилжүүлэн “Харилцаа холбооны салбарт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ” байгуулж ажилладаг. Энэхүү хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах талаар хуульд тусгасан тодорхой зохицуулалт байхгүй байна.

с) ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг болон түүний улсын байцаагчийн өргөдөл, гомдол, мэдээллээр хяналт шалгалт явуулах чиг үүргээс зааглагдсан эсэх?

ХХЗХ-д ирсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэдэг бөгөөд хэрэв өргөдөл, гомдол нь зөрчлийн шинжтэй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу өөрийн хуулиар эрх олгогдсон улсын байцаагчид шилжүүлж шалгадаг байна.

ХХТХ-ийн 9.1.12-т ХХЗХ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, мөн хуулийн 31.2-т Энэ хуулийн 31.1-д зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Зохицуулах хороо, салбар зөвлөл шийдвэрлэнэ гэж тус тус заасан. Хэдийгээр ХХТХ-р ХХЗХ-д маргаан хянан шийдвэрлэх эрх олгогдсон боловч маргааныг хэрхэн хянах, маргааныг хянаад ямар шийдвэр гаргах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэж, хариу өгдөг байна.

Мөн түүнчлэн улсын байцаагчийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болох иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг болон ХХТХ-н 9.1.12, 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг нь ялгаатай байдлаар зохицуулагдаагүй байна.

д) Улсын байцаагчийн тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь ХХЗХ-ны энэ талаарх бүрэн эрхээс ялгагдаж байгаа эсэх

Энэ хүрээнд практикт гардаг нэг асуудал нь Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтийг шалгах аар үйлчилгээ эрхлэгч этгээдтэй харилцахдаа төрийн хяналт, шалгалтын удирдамжийн дагуу шалгана гэж удирдамж танилцуулдаг байна. Гэтэл хяналт шалгалт хийх этгээд нь улсын байцаагчийн эрхгүй ажилтан байдаг. Төрийн хяналт, шалгалтын удирдамжийн дагуу шалгах бол улсын байцаагчийн эрхтэй этгээд хяналт шалгалт хийх эрхтэй гэж үйлчилгээ эрхлэгчээс шаардлага тавьж энэ талаарх үл ойлголцол, зөрчил үүсдэг байна. ХХТХ-ийн 9.1.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтаар зөвшөөрөлтэй холбоотой бүх харилцаа, нөхцөл, шаардлага, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих бүхэн эрхийг ХХЗХ-нд олгосон бөгөөд тус хороо нь энэхүү эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Харин улсын байцаагчийн тусгай зөвшөөрлийн олголт, түүний хэрэгжилтэд хяналт тавих эрх нь тусгай зөвшөөрлийг хууль, тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу олгож байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа юм. Одоогийн байдлаар ХХЗХ-нд хуулиар эрх олгосон улсын байцаагч нар хэрэгжилтийг хангуулан, хяналт тавин ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтнүүд (зөвхөн харилцаа холбооны чиглэлээр мэргэжил эзэмшсэн ажилтнууд) Харилцаа холбооны тухай

хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтаар олгосон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх харилцаа, түүний биелэлтэд, мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтаар зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавихаар зохицуулсан боловч хяналт тавих ажиллагааг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан заагаагүй байна.

Харин Харилцаа холбооны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалтаар улсын байцаагчид тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтийг хянан шалгах бүрэн эрхийг олгосон байна. Өөрөөр хэлбэл зөвхөн улсын байцаагчийн эрхтэй мэргэжилтнүүдэд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрхийг олгожээ.

Төрийн хяналт шалгалт гэдэг нь өргөн агуулгаар хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэрт нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, алдаа дутагдал, зөрчил гарсан бол шуурхай илрүүлж, таслан зогсоох, үр дагаврыг арилгахад чиглэсэн төрийн үйл ажиллагааны хэлбэр юм.

Улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах, тэдгээрт шийтгэл оногдуулж, албадлагын болон зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, зардлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

Иймд ХХЗХ-ны мэргэжилтнүүд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтаар зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд урьдчилан хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж, чиглэлийг зөвшөөрөл эзэмшигч нарт хүргүүлэхээр байх ба зөрчил давтагдан гарах, эрсдэл үүсэж болзошгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу улсын байцаагчийн эрхтэй мэргэжилтнүүд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр байна.

2.6. ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

<p>Үнэлэх хэсэг, заалт</p>	<p>9 дүгээр зүйл.Зохицуулах хорооны бүрэн эрх</p> <p>9.1.Зохицуулах хороо харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.1.13.дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, уг үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын журам батлах;</p> <p>25 дугаар зүйл.Үйлчлэгчийн эрх, үүрэг</p> <p>25.2.Үйлчлэгч нь дараахь үүрэгтэй байна:</p> <p>25.2.9.хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх;</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • ХХЗХ дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, зохицуулалтын журам батлах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх.

	<ul style="list-style-type: none"> • Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлж чадсан эсэх, чадаагүй бол үүний шалтгаан нөхцөл юу байв? • Оператор компаниуд хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх үүргээ сайн дураар биелүүлж байгаа эсэх. • Дугаартайгаа шилжих үйлчилгээ нэвтрээгүйгээс шалтгаалж хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэх.
--	--

а) ХХЗХ дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, зохицуулалтын журам батлах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх.

і. Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрхийн тухайд:

Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрхийн заалт бүрэн гүйцэд хэрэгжээгүй байна.

Тодруулбал, ХХТХ-ийн 9.1.13, 25.2.9 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-ны даргын 2014 оны 09 сарын 29-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/176 дугаар тушаалын 1-р хавсралтаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2-р хавсралтаар ажлын хэсгийн удирдамжийг тус тус баталжээ. Улмаар тус ажлын хэсэг нь техник технологийн болон эдийн засгийн дэд ажлын хэсэг байгуулж, удирдамжид заасан ажлуудыг¹¹ хийж гүйцэтгэж байжээ. Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ:

Он сар өдөр	дугаар	Баталсан хууль, журам	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
2015.06.12	26	Дугаартай шилжих үйлчилгээний ерөнхий журам	
2015.09.30	49	Дугаартай шилжих үйлчилгээний ерөнхий журамд оруулсан өөрчлөлт оруулах тухай тогтоол	
2015.10.03			<p>Үндсэн болон дэд ажлын хэсгүүд нийтдээ 10 орчим удаагийн уулзалт хурал хийсэн байна.</p> <p>Ажлын хэсгээс дараах ажлуудыг хийсэн:</p> <ul style="list-style-type: none"> • Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээний төв (“ДШҮТ”)-ийн хувилбаруудаас

¹¹ “Дугаартайгаа шилжих үйлчилгээ (mobile number portability)-г монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх” ажлын хэсгийн тайлан. УБ хот, 2015 он.

			<p>сонголт хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Операторын тоног төхөөрөмжид хийгдэх техник технологийн шийдлийг тодорхойлсон • Операторууд өөрийн төлбөр тооцоог өөрчлөх шинэчлэх хөрөнгө оруулалтын тооцоо гаргах, • Харилцан холболтын төлбөр, үнэ тарифын зохицуулалтыг тодорхой болгох • Үйлдвэрлэгчээс технологи судлах
2016.02.05	05	ДШҮТ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай нөхцөл шаардлага	
2016.05.25	28	ДШҮТ-ийн тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоол	
2020.04.29	23	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг батлах тухай тогтоол	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад дугаартай шилжих үйлчилгээний нөхцөл шаардлагыг бүрдүүлэх тухай тусгасан.

Ажлын хэсгээс дээрх ажлуудыг шат дараатай хийж гүйцэтгэж байсан боловч дугаартайгаа шилжих үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлж чадаагүй байх тул дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрхийн заалт бүрэн гүйцэд хэрэгжээгүй гэж дүгнэсэн болно.

ii. Дугаартайгаа шилжих үйлчилгээний зохицуулалтын журам батлах бүрэн эрхийн тухайд:

Дугаартайгаа шилжих үйлчилгээний зохицуулалтын журам батлах бүрэн эрхийн заалт хэрэгжсэн байна.

Тодруулбал, ХХТХ-д 2014 оны 7 сарын 01-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 3.1.13 дахь заалтад “дугаартайгаа шилжих үйлчилгээ” гэсэн нэр томъёог¹² тусгаж, 9.1.13 дахь заалтыг ХХЗХ-ны хэрэгжүүлэх бүрэн эрхэд нэмж тусгажээ. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 26 тоот тогтоолын хавсралтаар “ҮҮРЭН ХОЛБООНЫ ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЖУРАМ”¹³ -ыг баталсан байна. Энэхүү журмаар дугаартайгаа шилжүүлэх үйлчилгээнд хамаарах нэр томъёонуудыг тодорхойлж, дугаартайгаа шилжих үйлчилгээний ерөнхий зарчим, оролцогч талууд (ХХЗХ, ДШҮТ, оператор, донор оператор, хүлээн авагч оператор)-ын эрх үүрэг, дугаартайгаа

¹² "дугаартайгаа шилжих үйлчилгээ" гэж хэрэглэгч нэг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлээс гарч бусад цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид бүртгүүлэн хэрэглэгч болох үедээ одоогийн ашиглаж байгаа дугаараа шилжүүлэн хэрэглэх боломж олгох үйлчилгээг ойлгоно.

¹³ <https://www.crc.gov.mn/storage/PDF/2015/togtool-2015-26.pdf>

шилжих хүсэлт гаргах, түүнийг шалгаж, бүртгэх, идэвхжүүлэх, гомдол маргаан хүлээн авах, шийдвэрлэх асуудал болон хариуцлагын талаар тус тус зохицуулжээ.

b) Дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлж чадсан эсэх, чадаагүй бол үүний шалтгаан нөхцөл юу байв?

А. ХХТХ-ийн 9.1.13 дахь заалт бүрэн гүйцэд хэрэгжээгүй буюу бодит байдалд хэрэгжих нөхцөл бүрдээгүй, дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлж чадаагүй байна. ХХЗХ-ны албан тушаалтнууд, оператор компаниуд, Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн удирдлагатай тус тус хийсэн ярилцлагаас үзэхэд дараах шалтгаануудын улмаас дугаартайгаа шилжих үйлчилгээ хэрэгжих нөхцөл бүрдээгүй гэж үзэхээр байна. Үүнд:

1. ДШҮТ байгуулагдаагүй.

ДШҮТ-ийг байгуулахаар 2015 оны 09 сарын 14-ний өдөр ХХЗХ/Т1/MNP/2015 дугаартай “Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээг хариуцан ажиллах төвийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох” нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, үйлчилгээг хариуцан ажиллах төвийг 2015 оны 12 сард сонгосон боловч ялагч нь 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/01 албан бичгээрээ тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулахаас татгалзсан байх бөгөөд үүнээс хойш дахин сонгон шалгаруулалт явуулаагүй байна. Ийнхүү ДШҮТ-ийг байгуулаагүйгээс шалтгаалж уг үйлчилгээ хэрэгжих боломжгүй болжээ. ХХЗХ-ны хувьд 4 оператор компани дундын төв байгуулахад зөвшилцөлд хүрч чадаагүй болохыг дурдаж байсныг¹⁴ онцлох хэрэгтэй.

2. Оператор компаниуд өөрсдийн тоног төхөөрөмжид техник технологийн өөрчлөлт шинэчлэл хийгээгүй

Оператор компаниуд нь ДШҮТ-ийг байгуулсан тохиолдолд бэлтгэл ажлаа хангахаар техник тоног төхөөрөмжийг тус төвийн тоног төхөөрөмжид тохируулан суурилуулахыг хүлээж байсан гэх шалтгаанаар одоог хүртэл тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагаа биелүүлээгүй байна.

3. Хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх боломжгүй гэж үзсэн.

Оператор компани нь үйлчилгээг үзүүлэхийн тулд ДШҮТ-д төлбөр төлөх бөгөөд уг төлбөрийг хэрэглэгчээс гаргахаар төлөвлөж байсан боловч хэрэглэгчид төлбөрийн дарамт үүсгэхээр судалгаа тооцоолол гарч байсан талаар ярилцлага хийх явцад хэлж байлаа. Тухайлбал, оператор компаниуд дундаасаа нийлж их хэмжээний (33 сая ам.доллар) хөрөнгө оруулалт хийж дундын төв байгууллаа гэхэд дугаартайгаа шилжиж байгаа хэрэглэгчдийн тоо нь хөрөнгө оруулалтын зардлаа нөхөж чадахгүй гэсэн тооцоолол гарсныг дурдаж байв.¹⁵

¹⁴ ХХЗХ-ны ЗБХГ-ын ХХСДБХ-ийн дарга Х.Нинжболортой 2023.06.22-ны өдөр хийсэн ярилцлагын үеэр дурдсан.

¹⁵ ХХЗХ-ны ЗБХГ-ын ХХСДБХ-ийн дарга Х.Нинжболортой 2023.06.22-ны өдөр хийсэн ярилцлагын үеэр дурдсан.

Б. Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.13, 25.2.9 дэх заалтууд 2014 оны 7 сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдал, үүрэн холбооны үйлчилгээ хэрхэн өөрчлөгдсөн болохыг он цагийн дарааллаар нь үзүүлвэл:

Огноо	Нөхцөл байдлын өрнөл
2014.09.29	ХХЗХ-ны даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталсан.
2015.06.12	“Дугаартай шилжих үйлчилгээний ерөнхий журам”-ыг баталсан.
2015.09.14	Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээг хариуцан ажиллах төвийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалт зарлав.
2015.12.25	Сонгон шалгаруулалтын ялагчийг шалгаруулж, тусгай зөвшөөрөл олгохоор болов.
2015.12.25	ХХЗХ-ны 68 дугаар тогтоолоор “Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэх зохицуулалтын чиглэл”-ийг баталж, 4G технологийг Монголд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэв.
2016.01.14	Ялагч нь дугаартайгаа шилжих үйлчилгээний төвийн тендерээс татгалзав.
2016.02.16	Үүрэн холбооны 4G LTE/LTE-A үйлчилгээг эрхлэх зөвшөөрлийг Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Скайтел ХХК-д тус тус олгож, 4G үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэв.
2016.05.04	ДШҮТ-ийг ХХЗХ дэргэдээ байгуулах эрхтэй болсон. Тодруулбал, радио давтамжийн хяналт, зохицуулалтын төвийн суурь дээр өөрчлөн байгуулж, дугаартайгаа шилжих үйлчилгээ, радио долгионы хяналт, контентийн зохицуулалт, радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хяналт, мониторингийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулахаар ХХЗХ-ны дүрэмд тусгасан. Дугаартайгаа шилжих үйлчилгээг эрхлэх нэгдсэн төвийг байгуулахад улсын төсвөөс хөрөнгө зардал гарахгүй, ХХЗХ өөрийн дотоод зардлаас зохицуулахаар шийдсэн.
2016.5	ДШҮТ-ийн техник хангамж, тоног төхөөрөмж нийлүүлэх тендер зарласан.
2016.6-7	Тендерийн ялагчийг тодруулсан.
2016.8.18	Засгийн газраас бүх тендерийг зогсоосон. Ингээд дээрх тендерийн хүчинтэй хугацаа дууссан.
2021.9.15	Анхны 5G сүлжээний туршилтын станцыг Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод асаасан.

Дээрх нөхцөл байдлын өрнөл, өөрчлөлтөөс харахад дугаартайгаа шилжих үйлчилгээг анх нэвтрүүлэх оролдлого эхэлсэн 2014 онд үүрэн холбоо 3G технологитой байсан бол түүнээс хойш 4G технологи бүрэн нэвтэрч, өнөөдрийн байдлаар 5G технологид шилжих эхлэл тавигдаад байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн 9 жилийн хугацаанд үүрэн холбооны технологи хурдацтай хөгжиж, хувьсан өөрчлөгдөж, үүрэн холбооны яриа үйлчилгээний үнэ тариф буурч, дугаартайгаа шилжих

үйлчилгээний хуулийн зохицуулалтын анхны зорилго биелсэн талаар ярилцлагын¹⁶ үеэр хэлж байлаа. Дугаартайгаа шилжих үйлчилгээг 2014 онд хуульд тусгасан гол зорилго нь хэрэглэгч хямд үнэтэй, чанартай, сайн үйлчилгээг авах нөхцөл бүрдүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих¹⁷ явдал байсан. Гэхдээ ХХЗХ-ноос 2014 онд хийсэн “МОНГОЛ УЛСАД ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН”¹⁸ -гаас харахад үүрэн холбоо анх нэвтэрсэн 1996 оноос 2013 он хүртэл сүлжээн доторх болон бусад сүлжээ рүү ярих ярианы тариф тогтмол буурч¹⁹ байсныг анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл ярианы тариф тогтмол бууж байсан үед дахин үнэ бууруулах нь дугаартайгаа шилжих үйлчилгээний туйлын зорилго мөн байсан эсэх нь эргэлзээтэй юм. Иймээс ХХЗХ-ноос дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ авсны үр дүнд үүрэн холбооны ярианы тариф буурч, хууль анх батлах үеийн зорилго биелсэн гэж шууд дүгнэх боломжгүй юм.

с) Оператор компаниуд хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх үүргээ сайн дураар биелүүлж байгаа эсэх.

ХХТХ-ийн 25.2.9 дэх заалт хэрэгжээгүй байна.

Оператор компаниуд хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх үүргээ сайн дураар биелүүлээгүй байна. Энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

А. Оператор компаниуд нь ДШҮТ-ийг байгуулсны дараа өөрсдийн техник тоног төхөөрөмжийг тус төвийн тоног төхөөрөмжид тохируулан суурилуулахыг хүлээж байсан боловч уг төв байгуулагдаагүй гэх тайлбарыг өгдөг.

Б. Оператор компаниуд биллинг систем дээрээ өртөг өндөртэй нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байсан ба ДШҮТ байгуулагдах эсэх нь тодорхойгүй нөхцөлд энэ хөрөнгө оруулалт нь операторуудын хувьд эрсдэл дагуулах байсан гэсэн 2 үндсэн шалтгаан буюу гадаад дотоод хүчин зүйлээс хамаарч дээрх үүргээ биелүүлээгүй болохыг оператор компаниудын төлөөлөл болон ХХЗХ-ны албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагын²⁰ үеэр дурдаж байсан.

Дээрх шалтгаануудын улмаас оператор компаниуд ХХТХ-ийн 25.2.9 дэх заалтыг сайн дураар биелүүлээгүй байна. Үүнээс шалтгаалж ХХЗХ-ны 2020.04.29-ний өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА (Телефон ярианы үйлчилгээнд)”²¹-ын 5.19 , 8.11 дэх хэсэг тус тус зөрчигдөж байна.

¹⁶ ХХЗХ-ны гишүүн, Ажлын албаны дарга А.Лувсан-Очиртой 2023.06.20-ны өдөр хийсэн ярилцлага.

¹⁷ <https://www.parliament.mn/nn/436/>

¹⁸ <https://crc.gov.mn/articles/slug10030/mn>

¹⁹ Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол Улсад дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх боломжийн талаарх суурь судалгааны тайлан, УБ.,2014, 11 дэх тал.

²⁰ “Скайтел” ХХК, “Мобиком” ХХК, “Юнител” ХХК болон ХХЗХ-ны албан тушаалтнууд болон Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн удирдлагатай хийсэн ярилцлага.

²¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211126&showType=1>

d) Дугаартайгаа шилжих үйлчилгээ нэвтрээгүйгээс шалтгаалж хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэх.

2014 онд ХХЗХ-ноос дугаартайгаа шилжих үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломжтой эсэхийг судалж, судалгааны тайлан²² гаргаж байсан ба үүнээс хойш дахин судалгаа хийгдээгүй, яг өнөөдрийн байдлаар үүрэн холбооны хэрэглэгч дугаартайгаа шилжих хэрэгцээ шаардлагыг судалсан судалгаа байхгүй байна. ХХЗХ-ны албан хүмүүстэй хийсэн уулзалт ярилцлагын үеэр тодруулахад дугаартайгаа шилжих үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж чадаагүйгээс болж гарч байгаа хүндрэл чирэгдэл, бэрхшээлийн талаар гомдол санал ХХЗХ-нд ирүүлээгүй болохыг хэлж байлаа.

Харин “Ондо” ХХК-ийн хувьд ХХТХ-ийн 25.2.9-д заасан үүргээ биелүүлэх хүсэлтэй байгаа төдийгүй, дугаартайгаа шилжих үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд хамтран ажиллах хүсэлтэй байгаа болохоо ХХЗХ-нд мэдэгдсэн²³ ба дугаартайгаа шилжих үйлчилгээний хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа гэдгээ судалгааны багтай уулзсан уулзалтын үеэр мэдэгдэж байсан.²⁴ Дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой хуулийн заалтуудын үйлчлэл нь нийгмийн харилцааны өөрчлөлт, харилцаа холбооны салбарын технологийн хөгжлөөс хоцорсон болохыг уулзалт ярилцлагын үеэр зарим оролцогчид²⁵ хэлж байсантай санал нийлж байна.

2.7. ҮНДСЭН СҮЛЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ

Үнэлэх хэсэг	<p>Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10-т “үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих”</p> <p>Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдсэн, нийтийн үйлчилгээнд зориулсан сүлжээг цахилгаан холбооны үндсэн сүлжээ гэнэ. Үндсэн сүлжээ нь төрийн өмчлөлд байж болно.”,</p> <p>Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Үндсэн сүлжээг төр, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж байгуулж, өмчилж болно.”</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none">• Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг баталсан эсэх?• Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл байгаа эсэх?• Үндсэн сүлжээг төр болон өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж байгуулж өмчлөхөд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх, өмчлөхтэй холбоотой асуудлаар маргаан дагуулж байгаа эсэх?

²² “Монгол Улсад дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх боломжийн талаарх суурь судалгааны тайлан” УБ.,2014, эх сурвалж: <https://crc.gov.mn/articles/slug10030/mn>

²³ “ОНДО” ХХК-аас ХХК-аас ХХЗХ-нд хандсан 2023.08.03-ны өдрийн 22/588 тоот албан бичиг.

²⁴ “ОНДО” ХХК-ийн Хуулийн зөвлөх Г.Оргилмаатай 2023.07.17-ны өдөр хийсэн ярилцлага.

²⁵ Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн Гүйцэтгэх захирал У.Тамир, ХХЗХ-ны гишүүн, Ажлын албаны дарга А.Лувсан-Очир нартай 2023.06.20-ны өдөр хийсэн ярилцлага.

а) Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг баталсан эсэх?

ХХТХ-д 2019.05.30-ны өдөр орсон өөрчлөлтөөр 6 дугаар зүйлийн 6.1.10-т "үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;" гэж батлагдсаныг 2021.12.17 өдрийн өөрчлөлтөөр "үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих" гэж "стратеги" гэсэн үгийг хасаж баталсан байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар Монгол Улсын Мэдээлэл, холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (2019-2024)-г баталсан. Энэхүү баримт бичигт Улс хоорондын сүлжээ, Хот хоорондын сүлжээ, Хот, суурин газрын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг тусгасан байна.

б) Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл байгаа эсэх?

Монголын харилцаа холбооны сүлжээний төлөвлөлт нь 1957-1970, 1970-1990, 1993-2010, 1993-2010, 1997-2015, 2013-2020 зэрэг хугацаа, он цагийн дараалал, тухайн цаг үеийнхээ хэрэгцээ шаардлага, судалгааны үндсэн дээр Монголын харилцаа холбоог хөгжүүлэх ерөнхий схем төлөвлөгөө, мастер төлөвлөгөө, Монголын харилцаа холбооны хөгжил, байршлын ерөнхий схем гэх мэт нэртэйгээр батлагдан хэрэгжиж байсан байна.²⁶ 1995 онд батлагдсан ХХТХ-н 4 дүгээр зүйлийн 3-т төрийн захиргааны төв байгууллага нь радио долгионы зурвасыг төлөвлөх бүрэн эрхтэй байхаар зохицуулсан. 2001 онд батлагдсан ХХТХ-н 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтад 2021.12.17 өдөр орсон өөрчлөлтөөр "үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих" төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хуульчилсан байна.

Дээрхээс үзвэл түүхэн уламжлал нь харилцаа холбооны сүлжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байсан бөгөөд 1995, 2001 оны ХХТХ-иудад төлөвлөх бүрэн эрх төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамаарч зохицуулагдан иржээ. Энэ асуудлаар үйлчилгээ эрхлэгч ААН-үүдийн хувьд "үндсэн сүлжээг төрөөс төлөвлөх асуудалд болгоомжтой хандаж, дэмжихгүй байгаа"-гаа илэрхийлж байсан болно. Учир нь төрөөс үндсэн сүлжээг хөгжүүлэх төлөвлөгөө гаргадаг байдал нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, нийгмийн тогтолцоо, зах зээл бүрэн нээгдээгүй тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байсныг үгүйсгэхгүй ч чөлөөт зах зээл, өрсөлдөөн бүхий өнөөгийн нийгмийн тогтолцооны хувьд үндсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөө байх шаардлагагүй, хувийн хэвшлийн үйлчилгээ эрхлэгчид зах зээлийн зарчмаар өөрсдөө үр ашигтай байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой, ингэснээр үр ашиггүй хөрөнгө оруулалтыг багасгах боломжтой, төр харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээнд баримтлах бодлогыг тодорхойлж, бодлогынхоо хүрээнд хүрэх үр дүн, үйлчилгээний төрөл, чанар, үүнийг хүргэх суурь сүлжээний багтаамж, хүчин чадлыг нь тодорхойлсон бодит зорилт бүхий бодлого (тоон утгаар

²⁶ "Монгол Улсын Харилцаа холбоог хөгжүүлэх ерөнхий схем – төлөвлөгөө ба мастер төлөвлөгөөний тухай" нийтлэл. Гавъяат холбоочин Н.Нансалжав. 2021.02.03

илэрхийлсэн КРІ тодорхойлох) хэрэгтэй гэж үзэж буйгаа илэрхийлж байсныг дурдах нь зүйтэй.

с) Үндсэн сүлжээг төр болон өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж байгуулж өмчлөхөд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх, өмчлөхтэй холбоотой асуудлаар маргаан дагуулж байгаа эсэх?

ХХтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдсэн, нийтийн үйлчилгээнд зориулсан сүлжээг цахилгаан холбооны үндсэн сүлжээ гэнэ. Үндсэн сүлжээ нь төрийн өмчлөлд байж болно.”, 17.4-т “ Үндсэн сүлжээг төр, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж байгуулж, өмчилж болно.” гэж заасан.


Дээрх хуулийн 2 заалтад төр болон өмчийн бүх төрлийн ААН үндсэн сүлжээг байгуулж, өмчилж болохоор заасан байна. Уг зохицуулалтын хэрэгжилттэй холбоотой талуудад хүндрэл гардаггүй, маргаан дагуулдаггүй байна.

2.8. БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>5 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 5.1.3.бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам батлах.</p> <p>11 дүгээр зүйл.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 11.1.Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор шуудангийн болон цахилгаан холбооны бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг тус тус бүрдүүлж, зарцуулна.</p> <p>11.2.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 11.2.1.хандив, зээл, тусламжийн хөрөнгө; 11.2.2.бусад хөрөнгө.</p> <p>11.3.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг зөвхөн энэ хуулийн 11.1-д заасан зориулалтаар зарцуулна.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн дүн болон хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн тоо, төсөвт өртөг • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалтын талаар үйлчилгээ эрхлэгчид болон төрийн болон зохицуулалтын байгууллагын албан хаагчид нэгдсэн ойлголттой байгаа эсэх? • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалт хоорондоо зөрчилдөж байгаа эсэх? • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгийг бүрдүүлэхэд үйлчилгээ эрхлэгч нарт тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл? • Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан зорилгодоо хүрсэн эсэх?

а) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн дүн болон хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн тоо, төсөвт өртөг

Зураг 2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн дүн



2009 оноос 2022 оны хооронд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд үйлчилгээ эрхлэгчдээс нийт 47,407,970,324 төгрөг татан төвлөрүүлж 38,655,669,820 төгрөгөөр төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.²⁷

Зураг 3. Санхүүжүүлсэн төслийн төрөл задаргаа



²⁷ <https://shilen.gov.mn/fund/info>

Харин Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгөөр 2009-2022 оны хугацаанд нийт 155 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Санхүүжүүлсэн төслүүдийг төрлөөр авч үзвэл 48.1% нь хөдөлгөөнт холбоо, 21.5% нь интернэт, 12.6% нь дэд бүтэц, 7.4% нь шуудан, 6.0% нь телевиз, радио, 4.1% нь судалгаа, сурталчилгааны төсөлд хамаарч байна.

b) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалтын талаар үйлчилгээ эрхлэгчид болон төрийн болон зохицуулалтын байгууллагын албан хаагчид нэгдсэн ойлголттой байгаа эсэх?

Харилцаа холбооны тухай хуулийн 11.1-т Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор шуудангийн болон цахилгаан холбооны бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг тус тус бүрдүүлж, зарцуулна гэж заасан.

Харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээ болон алслагдсан орон нутгийн талаар хууль тогтоомжид тодорхойлоогүй тул хэрхэн ойлгох талаар салбарын төрийн албан хаагчид, Зохицуулах хорооны албан хаагчид, үйлчилгээ эрхлэгчид нэгдсэн ойлголтгүй байна.

Ярилцлагын судалгааны явцад харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээ гэдэгт 1) яриа, мессеж болон 2) яриа, мессеж, интернэт гэж 2 байдлаар тодорхойлсон. Харин алслагдсан орон нутаг гэдгийг 1) сум, 2) засаг захиргааны хамгийн бага нэгж болох баг, 3) сумаас хэр хол байгааг үл харгалзан хүн амьдран суугаа газар нутаг гэж 3 байдлаар тодорхойлсон.

БНҮҮС-ийн талаар салбарын оролцогчид нэгдсэн ойлголтгүй байгаа нь БНҮҮС-ийн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөө батлах, салбарын оролцогчид БНҮҮС-ийн хөрөнгийн зарцуулалт нь БНҮҮС-ийн зорилгод нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөхөд бэрхшээл учруулж байна.

c) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохицуулалт хоорондоо зөрчилдөж байгаа эсэх?

Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.8-т "бүх нийтийн үйлчилгээний үүрэг" гэж төрийн бодлогын хүрээнд шуудангийн болон цахилгаан холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэхийг хэлнэ гэж, 3.1.9-т "бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан" гэж бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэхээр төвлөрүүлсэн хөрөнгийг хэлнэ гэж, 11.1-т Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор шуудангийн болон цахилгаан холбооны бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг тус тус бүрдүүлж, зарцуулна тус тус заасан. Харин Засгийн газрын тусгай сангийн тухай тухай хуулийн 9.1-т Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй

шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна гэж заасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.1-т дэх хэсэгт ... харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна гэсэн зохицуулалт Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.8-т заасантай нийцэхгүй бөгөөд БНҮҮС-ийн хөрөнгийг харилцаа холбооны дэд бүтэц бусад бүс нутгаас өндөр хөгжсөн, өрсөлдөөний зарчмаар интернэтийн шилэн кабель нэвтрүүлэх боломжтой, хэрэглэгч интернэтийн үйлчилгээг чөлөөтэй авах боломжтой бүс нутагт зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Тухайлбал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.1-т заасныг үндэслэн бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөнөөс 2021 онд Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг хүргэхэд 377,916,000 төгрөг, 2022 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нийт гэр хорооллын 1000 өрхөд, Чингэлтэй дүүргийн 14 (Хайлааст), 15 (Хайлааст), 18 (7 буудал)-р хорооны гэр хорооллын 760 өрхөд, Хан-Уул дүүргийн 14-р хороо (Өлзийт хороолол)-ны гэр хорооллын 1100 өрхөд, Булган аймгийн Дашинчилэн сумын 300 өрх, Говь-Алтай аймгийн Дарви сумын 210 өрх, Тайшир сумын 130 өрхийг өндөр хурдны шилэн кабелд холбоход 842,139,724 төгрөг зарцуулсан байна.²⁸

d) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгийг бүрдүүлэхэд үйлчилгээ эрхлэгч нарт тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл?

БНҮҮС-ийн хөрөнгө төвлөрүүлэх харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмаар зохицуулж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.3-т харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна гэсэн заалт нь үйлчилгээ эрхлэгч нарт хүлээн зөвшөөрөгдөхгүй байна.

Татвар төлсний дараах цэвэр ашиг нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны дагуу олсон, чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй цэвэр ашиг боловч үүнээс 3 хувийг татан авч байгаа нь татварын суурь зарчимтай зөрчилдөж байна. Энэ 3 хувь нь улсын нэгдсэн төсөвт шууд ордог орлого боловч албан татвар, төлбөр, хураамжийн аль болох нь тодорхойгүй байгаагаас үйлчилгээ эрхлэгчид санхүү, татварын тайланд хэрхэн тусгах нь тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

Мөн харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээнээс гадна бусад үйлчилгээнээс орлого олдог. Тухайлбал харилцаа холбооны оператор компани тусгай зөвшөөрөлд заасан үүрэн холбооны үйлчилгээнээс гадна гар утас, техник, тоног төхөөрөмжийн борлуулалт, үндсэн сүлжээний түрээс зэрэг үйл ажиллагаанаас орлого олж байна. Гэвч Засгийн газрын

²⁸ <https://shilen.gov.mn/fund>

тусгай сангийн тухай хуулиар үйлчилгээ эрхлэгчээс төвлөрүүлэх хөрөнгийг тооцох суурь түвшинг бүх үйл ажиллагааны орлогод үндэслэж байгааг өөрчлөх саналыг үйлчилгээ эрхлэгчдээс гаргаж байгааг дурдах нь зүйтэй.

Мөн түүнчлэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.3-т БНҮҮС-д төвлөрүүлэх хөрөнгийг давхардуулан ногдуулахгүй байх зохицуулалт байхгүйгээс группийн зохион байгуулалттай толгой хуулийн этгээд нь охин компанийн төлсөн хураамж дээр нэмж хураамж төлөх буюу БНҮҮС-д хөрөнгө давхардуулан төвлөрүүлж байна.

е) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан зорилгодоо хүрсэн эсэх?

БНҮҮС-ийн зохицуулалт Харилцаа холбооны тухай хууль 2001 онд батлагдахад шинээр орж ирсэн. Харилцаа холбооны тухай хуулийг УИХ-д 2001 онд өргөн мэдүүлэх цаг үед хөдөлгөөнт холбооны үйлчилгээг 2 компани, интернэтийн үйлчилгээг 5 компани эрхлэн явуулж, хөдөлгөөнт холбооны үйлчилгээг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сүхбаатар зэрэг цөөн хотуудад явуулж байсан²⁹, Монгол Улсад интернэтийн үйлчилгээ өргөн дэлгэрээгүй, харилцаа холбооны үйлчилгээ нь яриа, мессежэд тулгуурласан байжээ. Иймд зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээ гэдэгт яриа, мессежийг ойлгох боломжтой байна. 2023 оны байдлаар харилцаа холбооны үйлчилгээ 330 сумын бүх сумдад хүрсэн, 2003-2022 оны хооронд суурин телефон холбоо хэрэглэгчдийн тоо 144,5 мянгаас 475,3 мянга болсон, үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 301,0 мянгаас 4,8 сая /давхардсан тоогоор/ болж нэмэгдсэн байгаагаас үзэхэд 2001 онд Харилцаа холбооны тухай хуулиар анх батлагдсан тухайн үед тавьсан зорилгодоо хүрсэн гэж үзэх боломжтой юм. Мөн харилцаа холбооны салбарын хурдтай хөгжил, иргэдийн харилцаа холбооны суурь хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж байгаатай уялдуулан санг тухай бүр өөрчлөн зарцуулж иржээ. Гэвч БНҮҮС-ийн зорилгыг салбарын хөгжилтэй уялдуулан тодорхойлж өөрчлөөгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс бүрдүүлдэг БНҮҮС-ийн хөрөнгийн зарцуулалт нь зорилгодоо нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй, эргэлзээ төрүүлэх түвшинд хүрсэн гэж үзэж байна. Иймд тус сангийн зорилгыг төрийн бодлого, технологийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн томъёолж байх эрх үүргийг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

2.9. ИНТЕРНЭТИЙН ДУНДЫН ХОЛБОЛТЫН ЖУРАМ

Үнэлэх хэсэг	<p>6.1. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.14.харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон дараах журмыг батлах:</p> <p>6.1.14.г.интернэтийн дундын холболтын журам.</p>
Томъёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Яам бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх? • Журмын төсөл өнөөдрийг хүртэл батлагдаагүй шалтгаан нөхцөлийн талаар? • Журмын хэрэгцээ шаардлага?

²⁹ Харилцаа холбооны тухай хуулийн танилцуулга, Харилцаа холбооны тухай хуулийн хувийн хэрэг 2001 он, УИХ-ын Тамгын газар

	<ul style="list-style-type: none"> • Журам батлагдаагүйгээс интернэт үйлчилгээ эрхлэгчдийн дунд дундын холболттой холбоотой хүндрэл, бэрхшээл гарч буй эсэх? • Уг хүндрэл бэрхшээлийг зохицуулж чадсан эсэх? Зорилгод хүрсэн байдал? • Яаманд журам батлах бүрэн эрх олгосон нь практикт нийцэж байгаа эсэх?
--	---

a) Яам бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэх?

Харилцаа холбооны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 хавсралтаар батлагдсан “**Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Интернэтийн үйлчилгээнд)**”-аар харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн интернэтийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоосон байх бөгөөд уг шаардлагын 3.3 дахь хэсэгт “Үйлчилгээний чанарыг сайжруулах, сүлжээн болон үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь төрөөс зохион байгуулсан “Интернэтийн дундын холболт”-ын төвтэй (layer2) холболт үүсгэх” талаар үүрэгжүүлж, ерөнхий зарчмыг тогтоосон байна. Энэ хүрээнд интернэтийн болон контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгчийг интернэтийн дундын холболтын төхөөрөмжид холбох, түүний үйл ажиллагааг хэвийн явуулахтай³⁰ холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилго бүхий интернэтийн дундын холболтын журмыг Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульд заасан байна.

Гэвч яамны зүгээс интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс уг харилцаа нь интернэт үйлчилгээ эрхлэгчид интернэтийн дундын холболтын төхөөрөмжид холбогдох талаар дээрх зохицуулалтаас өөр зохицуулалтгүйгээр өнөөдрийг хүрээд байна.

b) Журмын төсөл өнөөдрийг хүртэл батлагдаагүй шалтгаан нөхцөлийн талаар?

Интернэтийн дундын холболтын үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий интернэтийн дундын холболтын журмыг батлах бүрэн эрхийг бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагад харьяалуулахаар хуульчилсан нь оновчгүй бөгөөд практикт нийцээгүй байна.

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнө Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан интернэтийн дундын холболтын журмаар дээрх харилцааг албан бусаар зохицуулж байсан боловч Харилцаа холбооны тухай хуульд

³⁰<https://old.mddc.gov.mn/%D0%B8%D0%BD%D1%82%D0%B5%D1%80%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B4%D1%83%D0%BD%D0%B4%D1%8B%D0%BD-%D1%85%D0%BE%D0%BB%D0%B1%D0%BE%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD-%D0%B6%D1%83%D1%80%D0%BC%D1%8B%D0%BD/>

2019 оны 05-р сарын 30-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхийг салбарын асуудал хариуцсан агентлаг хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Гэвч тус хуульд 2021 оны 11-р сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 6.1 дэх хэсгийн “холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчилснөөр интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхийг агентлаг бус Цахим хөгжил, харилцаа холбооны яам хэрэгжүүлэхээр болсон байна.

Төрийн захиргааны байгууллага буюу агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх³¹ чиг үүрэгтэй бол төрийн захиргааны төв байгууллага буюу яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхлэх бөгөөд сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, бодлого боловсруулах³² зэрэг нийтлэг ажлуудыг эрхэлнэ.

с) Журмын хэрэгцээ шаардлага?

Интернэтийн дундын холболтын үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, төлбөр, хураамжийн асуудал, интернэтийн дундын холболтын үйл ажиллагаан дахь төрийн захиргааны төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх, үндэсний дата төв, хувийн дата төв, интернэт үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүрэг, хариуцлага зэрэг асуудлыг журмаар зохицуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага байсаар байна.

д) Журам батлагдаагүйгээс интернэт үйлчилгээ эрхлэгчдийн дүнд дундын холболттой холбоотой хүндрэл, бэрхшээл гарч буй эсэх?

Дээрх журам батлагдаагүйгээс үүдэн үндэсний дата төв болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хооронд интернэтийн дундын холболтын үйл ажиллагаатай холбоотой асуудал, хүндрэл, бэрхшээл гарч байгаагаас дүгнэхэд, Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.г дэх заалт нь зорилгодоо хүрээгүй буюу интернэтийн дундын холболтын үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг журмаар зохицуулах хэрэгцээ, шаардлага хангагдаагүй байна. Тухайлбал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07-р сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалын хавсралтаар “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Үндэсний дата төвөөс үзүүлэх үйлчилгээнд 2023 оны 02-р сарын 01-ний өдрөөс эхлэн төлбөр тооцож эхэлсэн бөгөөд тус журмын 10.3 дахь хэсэгт интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээний төлбөрийг Үндэсний дата төв тогтоохоор заасны дагуу тус төв нь интернэтийн дундын холболтын хураамж /нэг удаагийн/ 2,000,000 төгрөг, интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээний төлбөр сар бүр 200,000 төгрөг байхаар тус тус тогтоосон байна. Интернэтийн дундын холболтын төхөөрөмжид холбогдоход төлж буй дээрх хураамж нь илт үндэслэлгүй, хэт өндөр байгаа талаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс холбогдох байгууллагад

³¹ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.

³² Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.

санал, шаардлага хүргүүлж ирсэн бөгөөд тухайлбал, интернэтийн үйлчилгээ эрхлэгч (ISP) “Ондо” ХХК-ийн зүгээс дээрх 2,000,000 төгрөгийн хураамжийг эс зөвшөөрч, дээрх хураамж илт үндэслэлгүй, өндөр байгаа тул гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй байгаа талаар дурдсан “Мэдэгдэлд хариу өгөх тухай” 23/83 тоот албан бичгийг 2023 оны 02-р сарын 17-ны өдөр “Үндэсний дата төв” УТҮГ-д, “Журмын заалтад өөрчлөлт оруулах тухай” 22/118 тоот албан хүсэлтийг 2023 оны 02-р сарын 28-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд тус тус хүргүүлж байсан байна.

е) Уг хүндрэл бэрхшээлийг зохицуулж чадсан эсэх? Зорилгод хүрсэн байдал?

Интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхийг төрийн захиргааны төв байгууллагад олгож хуульчилснаас үүдэн, уг журам өнөөдрийг хүртэл батлагдаагүй, төхөөрөмжид холбогдох төлбөр, хураамж, нэмэлт холболт, техникийн асуудалтай холбоотойгоор хүндрэл, бэрхшээл үүссээр байгаа тул Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.г дэх заалт нь зорилгод хүрээгүй байна гэж дүгнэлээ.

ф) Яаманд журам батлах бүрэн эрх олгосон нь практикт нийцэж байгаа эсэх?

ЦХХХЯ-нд интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхийг олгож хуульчилсан нь практикт нийцээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 05-р сарын 23-ны өдрийн 268 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 1.1 дэх хэсэгт зааснаар тус хороо нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд дүрмийн 1.3-т Хороо нь харилцаа холбооны талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, үйлчлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, үйлчлэгчийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилгын хүрээнд ажиллахаар тусгасан байна. Дээр дурдсанаар интернэтийн дундын холболтын төхөөрөмжид холбогдох техникийн нөхцөл, шаардлага, үнэ тарифыг тогтоох, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих, шинээр үйлчилгээ эрхлэгч төхөөрөмжид холбогдоход саад бэрхшээл учрахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах нь Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэгт илүүтэй нийцэж байна.

2.10. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Үнэлэх хэсэг	<p>5 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</p> <p>5.1.Засгийн газар харилцаа холбооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.5.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журмыг батлах.</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам батлагдсан эсэх, батлагдаагүй бол

	<p>түүний шалтгаан?</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний байгууллагын хэрэгцээ шаардлага байгаа эсэх?
--	---

а) Судалгаа, шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам батлагдсан эсэх, батлагдаагүй бол түүний шалтгаан?

ХХТХ-ийн 5.1.5-д заасан “харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журмыг батлах.” бүрэн эрх нь хэрэгжээгүй буюу судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам нь өнөөдрийн байдлаар батлагдаагүй байна.

2020 оны 11-р сард Монгол Улсад Ковид-19-ийн халдвар дотоодод анх удаа бүртгэгдэж гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу хатуу хөл хорио, хэсэгчилсэн хөл хорио тогтоож төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа урт хугацаанд алдагдсан, Ковид-19 цар тахлын улмаас улсын эдийн засагт гадаад, дотоод орчны нөлөөгөөр хямрал үүссэн тул Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолоор шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн. Мөн түүнчлэн 2022 оны 4-р сарын 29-ны өдөр Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, тус хуулийн 17.1.1-т чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх талаар заасан. Эдгээр нөхцөл байдал нь ХХТХ-ийн 5.1.5-т заасан судалгаа, шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам батлагдахгүй байх шалтгаан болсон байна.

б) Судалгаа, шинжилгээний байгууллага хэрэгцээ шаардлага байгаа эсэх?

ХХТХ-ийн 5.1.5-дахь заалтыг 2019 оны 05-р сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн. Тус хуулийн хэрэгцээ шаардлагын урьчилсан тандан судалгааны тайланд “мэдээллийн технологи, харилцаа холбооны судалгаа-хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, бодлого, зохицуулалтын болон шинэ техник технологи бүтээх, үйлдвэрлэх, нэвтрүүлэхтэй холбогдолтой суурь судалгаа хийх чиг үүрэгтэй судалгаа, шинжилгээний төвийг төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам баталж, салбарын судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох шаардлагатай байна” гэж дүгнэжээ³³. Мөн тус хуулийн төслийн үзэл баримтлалд “5. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын 2.3.4-д мэдээлэл, харилцаа холбооны судалгаа-хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинжлэх ухаан технологийн парк байгуулах арга хэмжээ авч Монгол Улсад инноваци, судалгаа-хөгжлийн нэгдсэн тогтолцоо бий болгоно гэж

³³ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлан, 49-р тал, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, 2019 он

заасан. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүднээс мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг явуулах, судалгааны үр дүнг бодлого, зохицуулалт, шинэ технологи хөгжүүлэх, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаатай холбосон хуулийн зохицуулалтын орчин бүрдүүлэх шаардлагатай байна” гэж тусгажээ. Гэвч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2021 оны 10-р сарын 13-ны өдрийн 314-р тогтоолоор Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/-ыг тус хуульд нийцүүлэх зорилгоор хүчингүй болгосон байна. Хэдийгээр хуулийн үзэл баримтлалд тусгасан бодлогын баримт бичиг хүчингүй болсон ч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.4.9-т Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацийн татваргүй бүсийг хамтын оффист түшиглэн байгуулна, 2.4.11-т “Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ” зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр заажээ. Үүнээс үзэхэд ХХТХ-ийн 5.1.5-т заасан судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, тус хуулийн 17.1.1-т чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх талаар заасан. Засгийн газрын 2016 оны 12-р сарын 21-ний өдрийн 194-р тогтоолоор "Шинжлэх ухааны парк-Мэдээллийн технологи"-ийг төрөөс мэдээллийн технологийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулан төлөвшүүлэх, шилдэг энтрепренёрийг бэлтгэх, гадаад аутсорсингийн үйл ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий "Мэдээлэл, технологийн үндэсний парк" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан. Иймд ХХТХ-ийн 5.1.5 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор чиг үүрэг ойролцоо байгууллагын хэлбэр, чиг үүрэгт өөрчлөлт оруулж хэрэгжүүлэх боломжтой байна.

2.11. ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>32 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>32.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>32.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>33 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх</p> <p>33.1.Харилцаа холбооны тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу гэм</p>
----------------------------	---

	буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • ХХтХ-ийг зөрчсөн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд бүрэн тусгасан эсэх • Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага нь үр нөлөөтэй байгаа эсэх

а) ХХтХ-ийг зөрчсөн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд бүрэн тусгасан эсэх

Харилцаа холбооны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт тус хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Улмаар Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд Харилцаа холбооны тухай хуулийг зөрчих зөрчил, түүнд оногдуулах хариуцлагын асуудлыг тусгасан байх бөгөөд шийтгэлийн төрлөөс торгох шийтгэл, албадлагын арга хэмжээнээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах арга хэмжээг зөрчлийн шинжийг харгалзан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулахаар заажээ.

Харилцаа холбооны тухай хууль зөрчих зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудал Зөрчлийн тухай хуульд бүрэн тусгагдаагүй байна. Тухайлбал, “харилцан холболт”-той холбоотой зөрчил практикт гарсан ч Зөрчлийн тухай хуульд хариуцлага оногдуулах зохицуулалт байхгүй. Энэ нь хууль хэрэгжүүлэхгүй байгаа ч Зөрчлийн тухай хуульд байхгүй бол зөрчил болохгүй байх тохиолдол болж байна.

Тохиолдол 1. ХХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж байгаа цаг үед “Ондо” ХХК-ийн нэхэмжлэлтэй ХХЗХ-нд холбогдох харилцан холболт хийлгүүлэхийг даалгах нэхэмжлэлийн шаардлагатай “Мобиком корпораци” ХХК, “Юнител” ХХК гуравдагч этгээдээр оролцож буй шүүхийн маргаан, “Мобиком” ХХК нарын нэхэмжлэлтэй ХХЗХ-нд холбогдох “Ондо” ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагатай шүүхийн маргаан хянан шийдвэрлэгдэж байна. Захиргааны хэргийн шүүхээс “Ондо” ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр буюу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлээгүй, тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж байгаа, ХХЗХ нь 2022.01.12-ны өдрийн 05/76 дугаартай албан бичгээр харилцан холболт хийхийг гуравдагч этгээдүүдэд үүрэг болгосон боловч “Мобиком корпораци” ХХК, “Юнител” ХХК нь хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор хариуцлага хүлээлгэх зохицуулалт Зөрчлийн тухай хуульд байхгүй байна.

б) Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага нь үр нөлөөтэй байгаа эсэх

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэхээр заасан шийтгэл, албадлагын арга хэмжээ нь зөрчлийн шинж, хохирлын хэм хэмжээнд тохироогүй, хөнгөн байгаагаас үүдэн Харилцаа холбооны хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт хангалтгүй буюу энэ төрлийн зөрчлийн тоон үзүүлэлт буурахгүй байна. Тухайлбал, зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр явуулах, салбарын үйлчилгээ эрхлэгчид үйлчилгээгээ хууль, гэрээнд заагаагүй үндэслэл,

шалтгаанаар таслах, салгах³⁴ зөрчлүүд буурахгүй, удаа дараа гарч байна. Тухайлбал:

Тохиолдол 2. “Монголын Цахилгаан Холбоо” ХК болон Монголын телевизүүдийн холбооны гишүүн, телевизийн үйлчилгээ эрхлэгч 10 байгууллага нь хуульд заасан урьдчилан мэдэгдэх болон гэрээндээ заасан журмыг хэрэгжүүлэлгүйгээр нэгэн зэрэг үйлчилгээгээ зогсоож хэрэглэгчдийн эрхийг хөндсөн асуудлыг ХХЗХ-оос дурдаж байна.

Мөн ХХТХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших хугацаанд Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хамгаалалтын зурвас газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан, урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ажил гүйцэтгэсэн зөрчлүүд хамгийн их буюу давтагдан гарсаар байна. Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хамгаалалтын зурвас газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан, урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ажил гүйцэтгэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан.

Гэвч дээрх дурдаж буй зөрчлүүдийн торгууль, хариуцлагын арга хэмжээ нь бага байгаагаас хүн, хуулийн этгээд нь хариуцлагыг үл тоон, өөрийн ажлыг саадгүй бүтээх зорилгоор зөрчил давтан гаргасаар байгаа нь Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох гэсэн шийтгэлийн зорилгод нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, Харилцаа холбооны тухай хуульд хариуцлагын заалтуудыг тусгасан ч дээрх шалтгаанаар хариуцлагын зохицуулалтууд нь зорилгодоо хүрээгүй, практикт үр нөлөөгүй байсаар байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, судалсан судалгааны үр дүнд дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Салбарын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх

- ЦХХХЯ-нд хуулиар олгосон бүрэн эрхүүд нь харилцаа холбооны салбарын харилцаануудыг бүрэн хамарсан боловч зарим бүрэн эрх нь бодлого тодорхойлохоос илүүтэй зохицуулалтын чиг үүрэгт хамааралтай байна.
- ХХТХ-ийн 6.1.3-т ЦХХХЯ-нд давамгайл байдлаа сэргээр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл батлах, 9.1.6-д ХХЗХ-нд харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах гэсэн ерөнхий бүрэн эрхийг тусгасан болохоос уг чиглэл болон журамд ямар үйл ажиллагаа, зохицуулалт хамаарахыг нарийвчилж тусгаагүйгээс Өрсөлдөөний тухай хуулийн 13.2-т заасан хуульд зааснаас бусад тохиолдол гэдэгт хамаарах эсэх нь тодорхойгүй, ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Өрсөлдөөний тухай хуулийн 6.3-т “Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ

³⁴ ЗТХ-ийн 9.3 дэх хэсэг.

хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй.” гэж заасан хэдий ч энэ нь зөвхөн зүй ёсны монополь байдалтай үйлчилгээ эрхлэгчид хамаарах зохицуулалт бөгөөд ердийн үйлчилгээ эрхлэгчдэд хамаарахгүй заалт тул ХХтХ-ийн 6.1.3, 9.1.6-д заасан бүрэн эрхүүд нь ШӨХТГ-тай чиг үүргийн давхардлыг үүсгэсэн, зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж дүгнэж байна. Иймд Өрсөлдөөний тухай хуульд “тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон зохицуулагч байгууллага нь салбарын үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөөний талаар бодлого, чиглэл, журам батлах” бүрэн эрхийг хуульчлах, эсхүл ХХтХ-д салбарын үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөөнийг зохицуулах нарийвчилсан зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

- ХХтХ-ийн 6.1.3-т “... өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл... батлах, хэрэгжилтийг зохион байгуулах” бүрэн эрх ЦХХХЯ-нд олгогдсон байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.6, 6.7 дахь хэсэг, заалтуудад зааснаар чиглэл батлах бүрэн эрх нь УИХ-д олгогдсон тул ХХтХ-ийн 6.1.3-т заасан баримтлах чиглэл батлах бүрэн эрх нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дээрх заалтуудтай зөрчилдөж байх тул ХХтХ-ийн 6.1.3-т заасан ЦХХХЯ-нд чиглэл батлах хэсгийг хасах шаардлагатай гэж дүгнэж байна.
- ХХтХ-д 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт өөрчлөлтөөр ХХтХ-ийн 6.1.14.в-д “төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам батлах” бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хуульчилж өгсөн байна. Харин радио, телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэх үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталжээ. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7-р зүйлд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх нийтлэг харилцааг зохицуулсан ба 29-р зүйлийн 29.1.5-д төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулах бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, 30-р зүйлийн 30.1.7.б-д өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг, 30.1.7.в-д олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулах бүрэн эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус олгожээ. Эндээс үзэхэд Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.14.в дэх заалтад тусгасан харилцааг сүүлд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар нарийвчилж зохицуулсан тул давхардал үүссэн байна. Иймд давхардлыг арилгахыг зөвлөж байна.

- ХХТХ-ийн 6.1.16-т “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих” бүрэн эрх ЦХХХЯ-нд олгогдсон байна. 2019 онд Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг заалтыг баталсан боловч УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон тус хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх байнгын хорооны танилцуулга ба хуулийн төсөлд энэ заалт байгаагүй. Харин УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар энэхүү заалтыг баталсан боловч энэ заалтын зорилго, эрх ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд, ямар хүрээнд батлах тухай мэдээлэл олдоогүй бөгөөд шууд тодорхойлох боломжгүй байна. Иймд ямар субъектийн харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ямар хүрээнд батлах нь тодорхой биш, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд авч үзвэл тэдний төлөвлөгөөг батлах нь бизнесийн үйл ажиллагаанд шууд оролцох асуудал тул уг заалт хэрэгжээгүй байна. Иймд төрийн байгууллага аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд шууд оролцох нь зохимжтой эсэх, зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн судалгаа, тус салбарт гарч байгаа шинэ техник, технологийн судалгаа, шинжилгээ хийх нь оновчтой эсэх, өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг дүгнэх шаардлагатай. Мөн түүнчлэн 2019 оны 5-р сарын 30-ны өдөр батлагдсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд салбар хоорондын зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатайг онцолж холбогдох зохицуулалтыг баталсан. ХХТХ-ийн 6.1.16 дахь заалтыг агуулга болон батлагдсан цаг хугацааны талаас нь авч үзвэл ХХТХ-ийн салбар хоорондын зохицуулалтад илүүтэй хамаарах боломжтой бөгөөд ХХТХ-ийн 6^{1.3}-т заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн эрхийг ЦХХХЯ-д олгоход чиглэсэн байж болох юм. Иймд ХХТХ-ийн 6.1.16 дахь заалт зайлшгүй байх шаардлагатай эсэхийг эргэн авч үзэх, хэрэв шаардлагатай гэж үзвэл ямар субъектийн харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ямар хүрээнд батлахыг тодорхой болгохыг зөвлөж байна.
- ХХЗХ-ны эрх зүйн байдлыг ХХТХ-ийн 8 дугаар зүйлд хуульчилж, 9 дүгээр зүйлд бүрэн эрхийг нь тогтоосон. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.3-т “захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;”-ийг захиргааны байгууллага гэж ойлгоно гэж хуульчилсны дагуу ХХЗХ-г захиргааны чиг үүргийг хуулийн үндсэн дээр шилжүүлж авсан этгээд, захиргааны байгууллага гэж үзнэ. Иймд ХХЗХ нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагын эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- ХХТХ-ийн 8.3-т ХХЗХ-ны дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 19 дэх хэсгүүдтэй зөрчилдөөгүй, нийцэж байна.

- Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд чөлөөт зах зээлийг хөгжүүлэх, чөлөөт зах зээлийг хөгжүүлэхэд бие даасан, хараат бус зохицуулах байгууллагыг байгуулах талаар хүлээсэн үүргээ биелүүлж ирсэн байна

2. Салбар хоорондын зохицуулалт

- Бусад салбаруудын хэрэгжүүлж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдэд нэгдмэл бодлого, төлөвлөлтөд хяналт тавих, чиглүүлэх чиг үүрэг, бүрэн эрх ЦХХХЯ-нд ХХТХ-ийн 6^{1.2}, 6^{1.3}, 6^{1.5}, 6^{1.6} хэсгүүдээр олгогдсон байна. ХХТХ-ийн 6^{1.1}-д заасан нэгдмэл бодлого, төлөвлөлтийг бий болгох, хяналт тавихын тулд харилцаа холбооны салбараас бусад салбар болон байгууллагуудын харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн бүртгэл, мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, мэдээллийн санг хөгжүүлэх шаардлагатай байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.26-д мэдээлэл хадгалагч нь “төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;”-г ил тод, нээлттэй байлгах үүрэг хүлээсэн, мөн тус хуулийн 29 дүгээр зүйлд нийтийн мэдээллийн систем байгуулахаар тусгасан ба уг системийн гол зохицуулагч нь ЦХХХЯ байхаар тус тус хуульчилсан тул дээрх шаардлагатай уялдаж ХХТХ-ийн 6^{1.1}-д заасан нэгдмэл бодлого, төлөвлөлт хэрэгжих бүрэн боломж бий болсон байна.
- Харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх хуулийн зохицуулалт бүрэн бүрдээгүй бөгөөд энэ нь бусад салбарын төрийн байгууллагуудад ХХТХ-ийн мэдлэг дутмаг, ХХТХ-ийн 6^{1.2}, 6^{1.3}, 6^{1.5}, 6^{1.6}-д тус тус заасан ЦХХХЯ-тай хамтран зохион байгуулах, санал авах, хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх үүргээ биелүүлээгүй бусад салбарын төрийн байгууллагын холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээлгэх зохицуулалт тодорхой бус, гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, зээл, хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, түүний төслийн нэгжийг салбар хоорондын харилцаанд оролцогчоор хуульчлаагүй байгаатай холбоотой байна.
- ХХТХ-ийн 6^{1.3}-т “Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.” гэж үүрэгжүүлж, зарчмыг тогтоосон байна. Ярилцлагын судалгааны хүрээнд холбогдох хүмүүстэй уулзахад дээрх зохицуулалтыг бусад салбарын байгууллагуудын харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл хөтөлбөрүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргах байдлаар хэрэгжүүлж байгаа гэдгийг мэдэгдсэн бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар нийт 6 төсөл, хөтөлбөрүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргасан нь дээрх заалт хэрэгжиж эхэлж байгааг харуулж байна. Гэхдээ хуулийн

зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх, үр нөлөөтэй болгох зорилгоор Засгийн газрын түвшинд мониторинг хийж хэвшүүлэхийг зөвлөж байна.

3. Хамгаалалтын зурвас газрын хэмжээ, инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас газрын давхцал

- Хамгаалалтын зурвас нь кабелийн шугамаас тал бүртээ 5 метр байна гэж заасан нь кабелийн шугамын аюулгүй байдлын талаасаа үйлчлэгч нар хүлээн зөвшөөрөгдөж байгаа боловч тухайн орон нутгийн инженерийн дэд бүтэц, шугам, сүлжээ байгуулах орон зайн багтаамж, газрын нэгдмэл сангаас бусдад олгосон газрын байршлаас хамаарч кабелийн шугамаас тал бүртээ 5 метрээс дотогш татах тохиолдлууд үүсэж байна. Иймд хамгаалалтын зурвасын хэмжээг орон нутгийн онцлогт нийцүүлэн уян хатан байдлаар тогтоодог болох нь зүйтэй байна.
- Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газар нь инженерийн дэд бүтцийн зурвас газартай давхацсан тохиолдолд Газрын кадастрын системд мэдээлэл дутуу орж байна. Ингэснээр инженерийн дэд бүтэц байгуулах этгээдүүд харилцаа холбооны сүлжээг гэмтээх явдал гарч байна.
- Харилцаа холбооны сүлжээ, байгууламж байгуулах ажил нь төр засгийн хувьд эдийн засаг болон нийгмийн өндөр ач холбогдолтой боловч бизнес эрхлэгчдийн хувьд санхүүжилт ихээхэн шаарддаг учраас тодорхой нэг чиглэлд ялангуяа орон нутаг, сум, баг руу уралдаж сүлжээ, байгууламж байгуулах шаардлага төдийлөн гардаггүйгээс газар эзэмших, ашиглах эрхийг нээлттэй дуудлага худалдаагаар авах зохицуулалт нь практикт нийцэхгүй, харин сөрөг үр дагавартай байна. Иймд дуудлага худалдааг хаалттай буюу зөвхөн харилцаа холбооны тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүд оролцохоор зохион байгуулдаг болохыг зөвлөж байна.
- Газрын дуудлага худалдааны анхны үнэ тогтоох зохицуулалт тодорхой биш байгаа учраас хамгаалалтын зурвас газрын төлбөртэй харьцуулахад хэт өндрөөр тогтоогдож байна. Кабель шугам нь 1 метр хүрэхгүй өргөнтэй газарт суурилагддаг, хамгаалалтын зурваст аливаа этгээд чөлөөтэй зорчих боломжтой байдаг тул газрын дуудлага худалдааны анхны үнэ тогтоохдоо хамгаалалтын зурвас газрын нийт талбайн хэмжээгээр биш зурвас газрын уртаар үнэлэхийг зөвлөж байна.

4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит

- ЦХХХЯ-аас харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх авсан хуулийн этгээд байхгүй, мөн түүнчлэн ЦХХХЯ нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг батлаагүй байна.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 3-т “Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд

аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.” гэж заасан байна. Дээрх хуулийн зохицуулалт нь “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж иш татаагүй “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж хуульчлагдсан байх тул УИХ-аас батлан гаргасан бүхий л хуулийг хамруулан ойлгоно. Иймд ХХТХ-ийн 30^{1.1}-д ЦХХХЯ нь аудит хийх хуулийн этгээдэд эрх олгохоор хуульчилсан тул Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдөөгүй байна. Гэвч ХХТХ-ийн 30^{1.1}-д эрх олгож байгаа үйлдэл нь Захиргааны ерөнхий хуулийн 37.1-д заасан захиргааны акт, мөн Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл олгох нэг хэлбэр гэж үзэх тул Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2-т заасан энгийн зөвшөөрлүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг оруулахыг зөвлөж байна.

5. Салбарын улсын байцаагчийн асуудал, маргаан шийдвэрлэх зохицуулалтын асуудал

- ХХЗХ-д ирсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэдэг бөгөөд хэрэв өргөдөл, гомдол нь зөрчлийн шинжтэй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу өөрийн хуулиар эрх олгогдсон улсын байцаагчид шилжүүлж шалгадаг байна.
- ХХТХ-н 9.1.12, 31.2-т зааснаар ХХЗХ-д маргаан хянан шийдвэрлэх эрх олгогдсон боловч маргааныг хэрхэн хянах, маргааныг хянаад ямар шийдвэр гаргах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэж, хариу өгдөг байна. Мөн түүнчлэн улсын байцаагчийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болох иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг болон ХХТХ-н 9.1.12, 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг нь ялгаатай байдлаар зохицуулагдаагүй байна.
- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т заасанд нийцүүлэн ХХТХ-н 8 дугаар зүйлийн 8.7, 30 дугаар зүйлийн 30.3 болон холбогдох хэсгийг өөрчлөх найруулах шаардлагатай. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд салбарын улсын байцаагчийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор практикт хэрэгжиж буй гэрээ байгуулах, бүртгэл мэдээллийн системд нэгдмэл байдлаар ажиллаж буй байдлыг хууль тогтоомжид тусгаж зохицуулах нь зүйтэй байна.
- ХХТХ-ийн 9.1.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтаар зөвшөөрөлтэй холбоотой бүх харилцаа, нөхцөл, шаардлага, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих бүхэн эрхийг ХХЗХ-нд олгосон бөгөөд тус хороо нь энэхүү эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Харин улсын байцаагчийн тусгай зөвшөөрлийн олголт, түүний хэрэгжилтэд хяналт тавих эрх нь тусгай зөвшөөрлийн хууль, тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу олгож байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа юм. Одоогийн

байдлаар ХХЗХ-нд хуулиар эрх олгосон улсын байцаагчид хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллаж байна.

- Салбарын улсын байцаагчийн өргөдөл, гомдол, мэдээллээр хяналт шалгалт хэрэгжүүлэх болон ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүргийг хуульд тодорхой тусгах нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулахад чухал нөлөөтэй юм.
- ХХЗХ-ны маргаан шийдвэрлэх чиг үүрэг нь маргалдагч талуудад хуулийн хариуцлага (санкци) хүлээлгэхгүйгээр талуудын хооронд үүссэн маргааныг таслах, мэргэжлийн байгууллага нь салбартаа үүссэн асуудлаа өөрөө шийдвэрлэх, шүүхэд хандахын өмнө зайлшгүй хийгдэх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болж байдгийг анхаарч хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

6. Дугаартайгаа шилжих үйлчилгээ

- ХХТХ-ийн 25.2.9 дахь заалт огт хэрэгжээгүй, 9.1.13 дахь заалт бүрэн гүйцэд хэрэгжээгүй гэж дүгнэв. Ийнхүү хууль хэрэгжээгүй ч гэсэн дугаартайгаа шилжих үйлчилгээг 2014 онд хуульд нэмж оруулсан гол зорилго болох хэрэглэгч хямд үнэтэй, чанартай, сайн үйлчилгээг авах нөхцөл бүрдүүлэх зорилго нь 4G, 5G үйлчилгээний нэвтрэлт, техник технологийн хөгжил, хэрэглэгчийн тооны өсөлт зэргээс хамаарч биелэгдсэн гэж үзэж байна. Хуулийн өөр нэгэн зорилго болох шударга өрсөлдөөнийг дэмжих тухайд хуулийн заалтыг хэрэгжүүлж, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх байр суурьтай байгаагаар зарим оператор компани³⁵ илэрхийлж байсан. Харин ХХЗХ-ны хувьд өрсөлдөөнд нөлөөлөх зорилго биелэгдсэн гэж үзэж байв. Судалгааны багийн зүгээс дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлээгүйгээс болж шударга өрсөлдөх боломж хаагдаж байгаа эсэх, үйлчилгээг нэвтрүүлснээр шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлэх эсэх талаарх нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүний дараа шударга өрсөлдөөнийг дэмжих хуулийн зорилгод хүрсэн эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй гэж үзлээ.
- Нэгэнт хуулийн заалтууд хэрэгжээгүй тул хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврын асуудал байхгүй байна. Мөн түүнчлэн хуулийн заалтууд хэрэгжихгүй байгаагаас хэрэглэгч болон оператор компани хохирч байгаа эсэх мэдээлэл, судалгаа байхгүй байна. Харин судалгаанд хамрагдсан хэд хэдэн оператор компанийн зүгээс ХХТХ-ийн 25.2.9-д заасан хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх үүргээ биелүүлье гэхээр эргээд нөхөгдөх боломжгүй их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болж эдийн засгийн алдагдалд орох тухай дурдаж, харин хөрөнгө оруулалтыг 5G технологийг нэвтрүүлэхэд зарцуулах нь илүү оновчтой тухай илэрхийлж байсан. Энэ нь хуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал хангагдахгүй байгааг илтгэж байна.

³⁵ “ОНДО” ХХК-тай 2023.07.17-ны өдөр хийсэн уулзалт болон 7.31-нд ирүүлсэн и-мэйлээр судалгааны багт байр сууриа илэрхийлж байсан.

- Үүрэн холбооны хэрэглэгч дугаартайгаа шилжих хэрэгцээ шаардлага өнөөдөр байгаа эсэх, дугаартайгаа шилжих үйлчилгээ нь технологийн хувьд хоцрогдсон эсэх, дугаартайгаа шилжих үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд оператор компаниудыг эдийн засгийн алдагдал, хохиролд оруулахаар байгаа юу гэдэг асуудлыг үүрэн холбооны оператор компаниуд болон хэрэглэгч иргэдээс асууж тодруулж,³⁶ хэрэглэгчийн судалгаа хийсний дараа ХХТХ-ийн 9.1.13, 25.2.9 дэх заалтуудыг хуулиас хасах эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна.

7. Үндсэн сүлжээтэй холбоотой заалтуудын хэрэгжилт

- Үйлчилгээ эрхлэгч ААН-үүд нь төрөөс үндсэн сүлжээг хөгжүүлэх төлөвлөгөө гаргадаг байдал нь хуучин нэгдсэн төлөвлөгөөт нийгэм, эдийн засгийн тогтолцоо, тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байсныг үгүйсгэхгүй ч чөлөөт зах зээл, өрсөлдөөн бүхий өнөөгийн нийгмийн тогтолцооны хувьд үндсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөө байх шаардлагагүй, хувийн хэвшлийн үйлчилгээ эрхлэгчид зах зээлийн зарчмаар өөрсдөө үр ашигтай байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой, ингэснээр үр ашиггүй хөрөнгө оруулалтыг багасгах боломжтой гэж үзэж байна. Иймд үндсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөг төрөөс батлах нь хувийн хэвшлийн байгууллагуудын эрх, ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл үүсэж болохоор байгааг анхаарах шаардлагатай. Төрөөс үндсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөг батлах шаардлагатай гэж үзвэл ХХТХ-ийн ерөнхий, тодорхой бус байгаа зохицуулалтыг тодорхой болгох дараах зөвлөмжийг анхаарч үзэх шаардлагатай гэж үзэж байна.
 - i. Төлөвлөгөөг батлахад оролцогч талуудаас зөвлөмж, санал авах, тэдний оролцоог хангах. Тухайлбал, ЗХ-оос зөвлөмж авах, орон нутаг, үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч, мэргэжлийн холбоодоос санал авах
 - ii. Төлөвлөгөөнд тодотгол, өөрчлөлт оруулах зэргээр төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлэх журмыг уян хатан болгох. Энэ нь батлагдсан төлөвлөгөөний биелэгдэх шинж чанарыг хадгалах ач холбогдолтой.
 - iii. Түүнчлэн хэрэглэгчид хүргэх үйлчилгээний төрөл, чанар, үүнийг хүргэх суурь сүлжээний багтаамж, хүчин чадлыг тооцох, тоон утгаар илэрхийлэгдсэн хүрэх үр дүн буюу зорилт тодорхой байх, төлөвлөгөө хэрэгжих, хамаарах хугацаа, хэрэгжилтийг хянаж шалгах, дүгнэх зохицуулалтыг тодорхой болгох,
 - iv. Үндсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах этгээд, хяналт тавих этгээдийг тодорхой болгоход анхаарах шаардлагатай.

8. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

³⁶ ХХЗХ-ноос 2014.04.25~30-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудаас түүврийн аргаар нийт 600 хэрэглэгчээс анкетын асуулгаар саналыг нь авч, МОНГОЛ УЛСАД ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУУРЬ СУДАЛГАА хийсний үндсэн дээр ХХТХ-ийн 3.1.13, 9.1.13, 25.2.9 дэх заалтуудыг тус хуульд 2014.7.01-ний өдөр нэмж оруулж байсан. Иймээс хуулийн эдгээр заалтуудыг хасахдаа мөн адил хэрэглэгчдээс саналыг нь авч, нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй гэж үзсэн болно.

- Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хөрөнгийг бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлж байгаа нь татварын суурь зарчимтай зөрчилдөж байна.
- Группийн зохион байгуулалттай хуулийн этгээдийн толгой хуулийн этгээд нь БНҮҮС-д хөрөнгө давхардуулан төвлөрүүлж байгааг засах шаардлагатай.
- 2023 оны байдлаар харилцаа холбооны үйлчилгээ 330 сумын бүх сумдад хүрсэн, 2003-2022 оны хооронд суурин телефон холбоо хэрэглэгчдийн тоо 144,5 мянгаас 475,3 мянга болсон, үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 301,0 мянгаас 4,8 сая /давхардсан тоогоор/ болж нэмэгдсэн байгаагаас үзэхэд 2001 онд Харилцаа холбооны тухай хуулиар анх батлагдсан тухайн үед тавьсан зорилгодоо хүрсэн гэж үзэх боломжтой юм. Мөн харилцаа холбооны салбарын хурдтай хөгжил, иргэдийн харилцаа холбооны суурь хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж байгаатай уялдуулан санг тухай бүр өөрчлөн зарцуулж иржээ. Гэвч БНҮҮС-ийн зорилгыг салбарын хөгжилтэй уялдуулан тодорхойлж өөрчлөөгүйгээс БНҮҮС-ийн хөрөнгийн зарцуулалт нь зорилгодоо нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй, эргэлзээ төрүүлэх түвшинд хүрсэн гэж үзэж байна. Иймд тус сангийн зорилгыг төрийн бодлого, технологийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчлэн томъёолж байх эрх үүргийг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.
- Олон Улсад бүх нийтийг харилцаа холбооны үндсэн үйлчилгээнд боломжит үнээр хамруулахын тулд БНҮҮС байгуулж зарцуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тодорхой үүрэг хүлээлгэх аргыг харилцан уялдаатай ашигладаг. Иймд Монгол Улсад БНҮҮС-н төлөвлөлт, зарцуулалтыг тусгай зөвшөөрөлтэй уялдуулсан зохицуулалт байхгүй байгааг тодорхой болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс сангийн хөрөнгийг төвлөрүүлж байгаагийн хувьд уг сангийн зарцуулалт, зориулалт нь эргээд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, цаашилбал харилцаа холбооны салбарын өсөлт, хөгжилд эергээр нөлөөлөхүйц байх зарчмыг баримтлах нь зүйтэй.

9. Интернэтийн дундын холболтын журам

- Интернэтийн дундын холболтын журам батлагдаагүйгээс үүдэн үндэсний дата төв болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хооронд интернэтийн дундын холболтын үйл ажиллагаатай холбоотой асуудал, хүндрэл, бэрхшээл гарч байгаа тул интернэтийн дундын холболтын үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг журмаар зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.
- Харилцаа холбооны тухай хуульд 2021 оны 11-р сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр интернэтийн дундын холболтын журмыг батлах бүрэн эрхийг бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий ЦХХХЯ-нд харьяалуулахаар хуульчилсан нь оновчгүй бөгөөд практикт нийцээгүй гэж дүгнэв. Интернэтийн дундын холболтын төхөөрөмжид холбогдох техникийн

нөхцөл, шаардлага, үнэ тарифыг тогтоох, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих, шинээр үйлчилгээ эрхлэгч төхөөрөмжид холбогдоход саад бэрхшээл учрахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах нь Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэгт илүүтэй нийцэж байх тул интернэтийн дундын холболтын журам батлах бүрэн эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд олгож хуульчлах нь илүү оновчтой гэж үзэж байна.

10. Судалгаа, шинжилгээний байгууллага

- ХХтХ-ийн 5.1.5-т заасан чиг үүрэгтэй судалгаа, шинжилгээний байгууллага байгуулж хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1-т заасны дагуу чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэх төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, чиг үүргийг өөрчлөх зэрэг арга хэмжээ авахыг зөвлөж байна.

11. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт

- ХХтХ-ийг зөрчих зөрчил Зөрчлийн тухай хуульд бүрэн тусгагдаагүй, зарим зөрчилд шийтгэл, хариуцлагын хэмжээ нь бага байгаагаас зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох гэсэн шийтгэлийн зорилгод нийцэхгүй байна.
- Иймд ХХтХ-ийг зөрчих зөрчлийн тоо, хэмжээг Зөрчлийн тухай хуульд нэмж тусгах, шийтгэл, хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой болохыг зөвлөж байна.